



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • VI • № 33

Н.БАЯРТСАЙХАН: **ХИЙХ
АЖИЛ ИХ, ТУЛГАРЧ
БУЙ СОРИЛТУУД ТОМ**

ЖЭФФ ГОТТЛИЙБ:
**ГАДААД ВАЛЮТЫН
НӨӨЦ ГУРВАН ТЭРБУМ
ДОЛЛАР ДАВСАН САЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД ГАРЛАА**

**"ЗЭЭЛИЙН ХҮҮНИЙ ДЭЭД
ХЯЗГААР ТОГТООХ БОЛОН
МӨНГӨ ХҮҮЛЭЛТТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ"
ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ
ХОЛБОГДУУЛАН
МОНГОЛБАНКНААС
ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ**



ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



БАНКНЫ ХӨГЖИЛ-95

Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн баярыг угтаж, Монголбанкнаас санаачлан “Банкны хөгжил-95 жил” аяныг хагас жилийн хугацаанд зохион байгуулав.

Тус аяны хүрээнд Монгол Улсын эдийн засаг, банк, санхүүгийн салбарын бодлогын асуудалд чиглэсэн нээлттэй хэлэлцүүлэг, онол практикийн бага хурал, сургалт уулзалтуудыг хийв.



“Монгол Улсын эрдэнэсийн сан”,
“Монголбанкны түүхийн альманах”,
“Монголын эзэнт улсын зоос, мөнгөн тэмдэгт”, “Монгол Улсын төлбөрийн хэрэгсэл”, “Монгол Улсын гүйлгээний болон дурсгалын зоос” гурван цуврал түүхийн бүтээл, “Монгол банк 95: Түүх ба баримт”, “Монгол төрийн эдийн засгийн бодлого: сорилт, сургамж, асуудал 1911-2018” номыг тус тус хэвлүүлэв.



Банкны хөгжил-95 жил үзэсгэлэнг 2900 хүн үзэж сонирхов.

Хөгжилд түүхээлсэн 95 жил баримтат нэвтрүүлэг, Монгол Улсын банкны салбарын хөгжлийн он цагийн товчоон хроник зэрэг бүтээлийг уншигч, үзэгчдэд толилуулав.



Банкны салбарын нийт ажилтан хамрагдсан “Сайн үйлсийн аян”-ы хандиваар Ардын зураач Л.Гаваагийн “Алтайн уулс” уран зургийг сэргээн засварлаж, Монголын уран зургийн галлерейн үзэсгэлэнгийн 4 танхимыг тохижуулав.



Нийт банкир, Төв банкны үе үеийн удирдлагууд, ахмад ажилтнуудаа хүндэтгэн урьсан ойн баярын хурлыг Соёлын төв өргөөнд зохион байгуулж, Монгол Улсын Консерваторын оюутан сурагчид урлагийн тоглолт толилууллаа.

Сүхбаатарын талбайд Банкны өдөрлөгийг харилцагчдын хамт тэмдэглэлээ.

Монгол Улсын консерваторын сургалтад зориулж АНУ-ын "Kimball" брэндийн төгөлдөр хуур болон Герман, Солонгос улсын хамтарсан "Samick" брэндийн төгөлдөр хуурыг бэлэглэлээ.



Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд банкны салбарын нийт ажилтан мод тарьж, марафон гүйлт болов.

Ногоон эдийн засгийн төлөө, эко банк байх үйлсэд нэгдэж, Тогтвортой санхүүжилт хөтөлбөрт нийт банк хамрагдав.



Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Монголбанк УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

4

Ярилцлага:

ХУУДАС

Хийх ажил их, тулгарч буй сорилтууд том

9

Асуулт, хариулт:

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас (2019.06.19)

15

**Монголбанкны
Эрдэнэсийн сангаас:**

ХУУДАС

Дурсгалын мөнгөн зоос

22

Нийтлэл:

ХУУДАС

“Миний мэргэжил,
миний бахархал”

23

Байр суурь:

ХУУДАС

Олон улсын зээлжих
зэрэглэлийн үнэлгээний
агентлагууд Монголын тухай

24

**Монголбанк
юу хийдэг вэ?:**

ХУУДАС

С.Ганбаяр Иргэд, аж ахуйн
нэгжүүд зээлээ хугацаандаа
төлөх эрмээзэлтэй болж байна

27

Дэлхийн үйл явдал:

ХУУДАС

Орчин үеийн банкны хөгжилд
гарсан зарим чухал ойлголт

30

**Мөнгөн тэмдэгтийн
түүх:**

ХУУДАС

1992 оны мөнгөн тэмдэгт

32

Банкир:

ХУУДАС

Жэфф Готтлийб: Гадаад валютын
нөөц гурван тэрбум доллар
давсан сайн үзүүлэлтүүд
гарлаа

33

Судалгаа:

ХУУДАС

“Зээлийн хүүний дээд
хязгаар тогтоох болон мөнгө
хүүлэлттэй тэмцэх тухай”
хуулийн төсөлтэй холбогдуулан
монголбанкнаас гаргасан
зөвлөмж

36



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ МЭДЭГДЭЛ

Огноо: 2019/06/19

Бодлогын хүүг хэвээр хадгалах тухай

Дугаар: 2019/02

Огноо: 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит хурлаар Бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Эдийн засгийн гадаад орчин, дотоод идэвхжилийг харгалзан үзэхэд инфляци зорилтот түвшний орчимд тогтворжих хандлага хэвээр байна. Жилийн инфляци 2019 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 7.9 хувьтай гарлаа. Инфляцийн хэлбэлзэл нь газрын тосны дэлхийн зах зээлийн үнийг дагасан шатахууны үнэ, нийлүүлэлтийн доголдоос шалтгаалсан махны үнийн огцом өөрчлөлтөөр тайлбарлагдаж байгаа бол эрэлтийн шалтгаантай суурь инфляци тогтвортой байна.

Уул уурхайн салбарын өсөлт энэ оны эхний улиралд хүлээлтээс давж, бизнесийн зээл тогтвортой өсч, хөрөнгө оруулалт, төсвийн зардал нэмэгдсэнээр эдийн засаг өсч байна.

Өнгөрсөн сараас дэлхийн худалдааны сөргөлдөөн гүнзгийрч, АНУ, БНХАУ импортын зарим барааны тарифыг харилцан нэмэгдүүлсэн нь дэлхийн эдийн засгийн өсөлт, түүхий эдийн үнийн цаашдын төлөвт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож, гадаад орчны тодорхой бус байдлыг нэмэгдүүллээ. Цаашид гадаад худалдааны нөхцөл муудаж болзошгүй байгаа нь уул уурхайн томоохон төсөл хэрэгжиж дуусах, гадаад өрийн том дүнтэй эргэн төлөлт эхлэх хугацаатай давхцаж байна. Иймд макро эдийн засгийн бодлогыг дотоод, гадаад тэнцвэрийг хадгалахад чиглүүлэх, улс орон, аймаг, орон нутаг, байгууллага, өрх гэр, хувь хүн хуримтлал, санхүүгийн нөөцөө нэмэгдүүлэх шаардлага эн тэргүүнд тавигдаж байна.

Гадаад орчны болзошгүй эрсдэлийг хохирол багатайгаар даван туулж, эдийн засгийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад төсвийн сахилга бат, банкны салбарын эрсдэл даах чадвар, төв банкны бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлэх нь чухал байна.

Макро эдийн засгийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв, гадаад дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг энэ удаад хэвээр хадгалахаар шийдвэрлэв. Уг шийдвэр нь инфляцийг зорилтот түвшний орчимд тогтворжуулах, макро эдийн засгийн болон санхүүгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалах зорилттой нийцэж байгаа болно.

Хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО

Монголбанк УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

2019.06.13

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Монголбанк 2018 оны үйл ажиллагааны тайлангаа танилцуулж, сүүлийн гурван жилд улс орны эдийн засгийг сэргээх, улсын өрийн дефолтоос зайлсхийх, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, дархлааг сэргээх, банк санхүүгийн салбарыг эрүүл, чийрэг болгох, Монголбанкныг орчин үеийн төв банкны жишигт хүргэн чадавхжуулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж буй талаар мэдээлэл хийлээ. Мөн цаашид Монгол Улс 2020-2024 оны хооронд төр болон хувийн хэвшлийн томоохон дүнтэй гадаад өр, төлбөрийг төлж барагдуулах, манай улсын экспортын гол түүхий эдүүдийн үнэ 2021 оноос буурах, ФАТФ-ын саарал жагсаалтад орох сорилтууд байгааг дурдаж, авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмжийг хүргүүлэхээр боллоо.



Азийн хөгжлийн банкны захирлуудын зөвлөлийн гишүүдийг хүлээн авч уулзав

2019.06.14



Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд Азийн хөгжлийн банкны үзүүлсэн дэмжлэг, туслалцаа их болохыг онцолж, АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Төлбөрийн системийн шинэчлэл” төсөл нь Монгол Улсын банк, санхүүгийн системийн хөгжилд өндөр ач холбогдолтойг тэмдэглэлээ. Мөн АХБ-ны санхүүжилтээр баригдаж буй Үндэсний цахим гүйлгээний төвийн шинэ барилгын ажил амжилттай үргэлжилж байгааг танилцуулав. Тэгвэл Азийн хөгжлийн банкны гүйцэтгэх захирлууд Монголын эдийн засагт богино хугацаанд сэргэлт гарч байгааг сайшааж, үүнд төсөв, мөнгөний хосолсон бодлого чухал үүрэг гүйцэтгэж байгааг онцлов. Мөн бүтцийн шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлэх нь чухал болохыг захиж, тулгарч буй сорилтуудаа олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмжлэг, тусламжтайгаар амжилттай даван туулна гэдэг итгэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.

ОУВС-ийн захирлуудын зөвлөлд Монгол Улсыг төлөөлөн ажиллаж буй гүйцэтгэх захирал Найжел Рэй Монголбанкинд ажиллав

2019.06.18

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан өнөөдөр ОУВС-ийн захирлуудын зөвлөлд Монгол Улсыг төлөөлөн ажиллаж буй гүйцэтгэх захирал Найжел Рэйг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр Монголбанкнаас “Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөв, сорилт”-ын талаар танилцуулга хийж, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусгах нь эдийн засагт тулгарч буй цаашдын сорилтыг даван туулахад чухал гэж үзэж “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн үр дүн, цаашид анхаарах асуудлаар харилцан санал солилцов. Ноён Рэй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” Монгол Улсад үр дүнгээ өгч байгааг тоон мэдээллүүд гэрчилж байна хэмээгээд, хүчирхэг банкны салбар, сахилга баттай төсөв, мөнгөний бодлого нь одоо хүрээд байгаа амжилтаа баталгаажуулахад чухал ач холбогдолтой болохыг онцолж, цаашид дэмжиж ажиллахаа илэрхийлэв.



Монголбанкны Хяналтын Зөвлөлийн хурлаар

2019.06.18



Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурлаар Монголбанкны Дотоод аудитын газрын үйл ажиллагаатай нарийвчлан танилцаж, олон улсын жишигтэй харьцуулан судалснаар санал дүгнэлт гаргахаар тогтов. Мөн Монголбанкны санхүүгийн балансын болон балансын гадуурх өр авлагын барагдуулалтын талаар Монголбанкны Хууль, эрх зүйн газрын мэдээллийг сонсч, Монголбанкны зүгээс өр авлага барагдуулах асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэсэн боловч, анхаарах хэрэгтэй зарим асуудлыг хэлэлцэв. Үүнд, банкны эрх хүлээн авагчид тухайн банкны өр авлагыг бүрэн барагдуулах, энэ талаар хүлээх хариуцлагыг эрс нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, өр барагдуулах хөшүүргийг зөв ашиглах, зарим өртэй байгууллага, хувь хүмүүсийг нийтэд мэдээлэх боломжтой гэв.

Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар санал солилцов

2019.06.19

Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг газрын захирлуудын хамтаар ОУВС-ийн Монгол Улсыг хариуцан ажиллаж буй гүйцэтгэх захирал Найжел Рэй болон ажлын хэсгийн ахлагч Жэф Готтлиб тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар инфляцийн болон эдийн засгийн ойрын хугацааны төлөв, хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн явц, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон юм. Энэ удаад ОУВС-ийн Дүрмийн IV заалтын дагуу хийгддэг үнэлгээний зөвлөлдөх хэлэлцүүлгийг гүйцэтгэхээр ажлын хэсэг Монгол улсад ажиллаж, бодлого боловсруулагч нартай уулзав.



Монгол Улс Олон улсын санхүүгийн боловсролын “Шилдэг түншлэл-2019” шагнал хүртлээ

2019.06.20



Монгол Улс Олон улсын хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролын байгууллага /Child&Youth Finance International/-ын “Шилдэг түншлэл-2019” шагнал хүртэв. Тус шагналыг Монгол Улс Олон нийтийн санхүү, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгээрээ хүртсэн бөгөөд 171 оронтой өрсөлдөж, шилдгээр тодорлоо. Олон улсын хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролын байгууллагын дээд хэмжээний 5-р уулзалт Өмнөд Африкийн Бүгд найрамдах улсын Йоханнесбург хотноо 6-р сарын 19-20-ны өдөр болж, тус уулзалтын үеэр “Дэлхий нийтийн санхүүгийн хүртээмж-2019” шагнал гардуулах ёслолын арга хэмжээн дээр Монгол Улс энэхүү нэр хүнд бүхий шагналаа гардан авсан юм. Шалгаруулалтад манай улс Ангола, Аргентин, Колумби, Марокко, Португали зэрэг улстай тунаж үлдэн тэргүүлэв.

Төв банкны суурь бүртгэлийн болон ERP системийг шинэчилнэ

2019.06.21

Монголбанк Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд Төв банкны суурь бүртгэлийн болон ERP систем нийлүүлж, суурилуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг зарлаж, “Intellect Design Arena” компанийг сонгон шалгаруулсан бөгөөд тус компанитай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Энэхүү төсөл нь олон улсын төв банкуудад хэрэгжиж буй “Intellect Quantum Central Banking” шийдлийг нэвтрүүлэх юм. Тус шийдэл нь суурь бүртгэлийн ерөнхий дэвтэр, банкны үйлчилгээ, төрийн үйлчилгээ, мөнгөний бодлого, зээл болон барьцаа хөрөнгийн удирдлага, валютын ханшийн удирдлага, гадаад худалдаа, Интернет банкны үйлчилгээ, нөөцийн удирдлага, төсвийн удирдлага гэх мэт хоорондоо нягт уялдаа бүхий байгууллагын удирдлагын модулиудыг агуулжээ. Тиймээс дэлхийн хамгийн цогц бөгөөд хүчирхэг төв банкны шийдэл болдогоороо онцлог юм.



ОУВС-ийн ажлын хэсэг Дүрмийн IV заалтын 2019 оны зөвлөлдөх яриа хэлэлцээг хийж дуусгалаа

2019.06.14.29



ОУВС-ийн ажлын хэсэг 2019 оны 6-р сарын 19-өөс 28-ны өдрүүдэд Монгол Улсад ажиллаж, ОУВС-ийн Дүрмийн IV заалтын дагуу хэрэгждэг 2019 оны зөвлөлдөх яриа хэлэлцээг хийлээ. Тус ажлын хэсгийн дүгнэлтэд эрх баригчид эдийн засагт гарсан нааштай өөрчлөлтөө зохистой ашиглаж, засгийн газрын тодорхой өрийг барагдуулж, гадаад валютын нөөцийг сэргээн нэмэгдүүлсэн ч эдийн засгийн буфер буюу хамгаалалт нь томоохон шокыг даван туулахад хүрэлцэхээргүй байгаа, эдийн засаг гадаад орчны болон уур амьсгалын өөрчлөлтөд хэт мэдрэг хэвээр, хэдийгээр эдийн засаг сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байгаа ч ядуурлын түвшин өндөр, Эдийн засгийн хамгаалалт бий болгох, бүтцийн өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх замаар өнөөг хүртэл хүрсэн үр дүнг өргөжүүлэх нь тэргүүлэх зорилт байх ёстой гэж дүгнэжээ. Мөн Эдийн засгийн өсөлтийг тогтвортой, хүртээмжтэй, ногоон болгоход санхүүгийн секторын шинэчлэлийг хэрэгжүүлэх, засаглалыг сайжруулах, хөдөө аж ахуйн бодлогыг шинэ түвшинд гаргах нь чухал ач холбогдолтой гэжээ.

ХИЙХ АЖИЛ ИХ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД ТОМ



Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхантай эдийн засагт гарч буй өөрчлөлт, “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хэрэгжилт, цаашдын сорилтын талаар ярилцсаныг уншигч Та бүхэнд хүргэж байна.

СҮҮЛИЙН 3 ЖИЛД ЭДИЙН ЗАСАГТ ЯМАР, ЯМАР ӨӨРЧЛӨЛТҮҮД ГАРААД БАЙНА ВЭ?

Эдийн засгийн нөхцөл байдал 2016 оны намар ямар хүнд байсныг Та бид мэдэж байгаа. Тухайн үед төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралтаас гадна Монгол Улсын цаашдын дунд, урт хугацааны төлөвт эрсдэл учрах нөхцөл байдал үүсээд байв. Ялангуяа төсвийн болон гадаад өрийн тогтвортой байдлыг хангах, өрийн дефолтоос зайлсхийх асуудал том сорилт болж байлаа. Тухайлбал, Хөгжлийн банкны 580 сая ам.долларын эргэн төлөлт 2017 оны 3 дугаар сард, Хятадын Ардын банк (ХАБ) болон Монголбанкны хооронд байгуулсан төгрөг, юанийн своп хэлцлээр Монголын талын авч ашигласан юанийн эргэн төлөлт 2017

оны 8 дугаар сараас эхлэх, Чингис бондын 500 сая ам.долларын эргэн төлөлт 2018 оны 1 дүгээр сард, Димсам бондын 1 тэрбум юань (160 орчим сая ам.доллар)-ий эргэн төлөлт 2018 оны 6 дугаар сард хийгдэхээр шилээ даран хүлээж байлаа.

Бидний өмнө эдийн засгийг тогтворжуулах, төсвийн болон өрийн тогтвортой байдлыг хангах, гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийг сэргээн нэмэгдүүлэх, эдийн засгийн хөөсрөлт-хагаралтын мөчлөгийг бууруулах, хүртээмжтэй өсөлтийг дэмжих зэрэг олон зорилт, сорилт байв.

Монголбанк сүүлийн 3 жилд улс орны эдийн засгийг сэргээх, улсын өрийн дефолтоос зайлсхийх, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, дархлааг сэргээх, банк

санхүүгийн салбарыг эрүүл, чийрэг болгох, Монголбанкийг орчин үеийн төв банкны жишигт хүргэн чадавхижуулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрлээ. Эдгээрээс цөөн хэдэн баримтыг дурдъя. Хугацаа нь тулаад байсан гадаад өр, төлбөрүүдийг амжилттай шийдвэрлэлээ. Эдийн засгийн өсөлт сүүлийн 2 жил гаруй хугацаанд эрчимжсэнээр өнөөдөр 8.6 хувьтай, инфляци сүүлийн 3 жилд зорилтот түвшинд, төсвийн алдагдал болон Засгийн газрын өрийн ДНБ-ий харьцаа буурсан, ГВАН 3.8 тэрбум ам.долларт (8-9 сарын импортын хэрэгцээг хангах хэмжээнд) хүрсэн, 2018 оны эцэст зээлийн хүү сүүлийн 6 жил дэх хамгийн бага түвшинд хүрч буурсан зэрэг нааштай өөрчлөлтүүд гараад байна.

“
**Миний итгэл
 үнэмшил бол
 Мөнгөний бодлогыг
 одоогийн түвшнээс
 сул байдлаар
 хэрэгжүүлэх нь
 инфляци, ханшийн
 сулралт, улмаар ГВАН
 хуримтлагдахгүй
 байх, улмаар
 эдийн засгийн
 дунд хугацааны
 тогтвортой байдал
 сөрөг үр дагавартай
 байхаар байна.
 Бид урагшаа харж,
 улс орны эрх
 ашгийг эрхэмлэж,
 дунд хугацааны
 тогтвортой байдлыг
 хадгалахын төлөө
 бодлого, шийдвэрээ
 гарган хэрэгжүүлж
 байна.**”

ЭДИЙН ЗАСГИЙН ЭНЭХҮҮ СЭРГЭЛТЭД МОНГОЛБАНКНЫ ҮҮРЭГ, ОРОЛЦОО ЮУ БАЙВ?

Бид сүүлийн 3 жилд Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ, тэдгээрийн үр дүнг нэгтгэн 5 бүлэгт хуваан үзэж байгаа.

Нэгд, Монголбанк санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийг эхлүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж байна. Банкны салбарын тулгуур хуулиуд болох Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зэрэг санхүүгийн салбарын суурь багана болсон эрх зүйн актуудыг боловсронгуй болгох үүднээс нэмэлт өөрчлөлтийн төслийг эрх бүхий байгууллагуудтай хамтран боловсруулж, УИХ-аар батлуулаад байна.

Хоёрт, Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т орох, орсны дараах үүрэг амлалтаа амжилттай хэрэгжүүлэн эдийн засгийн сэргэлтэд бодит хувь нэмэр оруулж байна. Дэлхийн эдийн засаг, түүхий эдийн зах зээл дээрх таатай байдал, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр, төсөв болон мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн шийдвэртэй арга хэмжээний үр дүнд эдийн засагт сэргэлт гарч байна. 2017, 2018 онд эдийн засагт тулгарч байсан олон сорилтыг амжилттай даван туулж, эдийн засаг сэргэсэн, банк санхүүгийн салбарт реформ

хийсэн шинэчлэлийн жилүүд болж өнгөрлөө.

Гуравт, Монголбанкны өөрийн хөрөнгө (хуримтлагдсан алдагдал) -3 их наяд төгрөг байсныг сүүлийн 2 жилд 1.2 их наяд төгрөгөөр бууруулж, цаашид эерэг болгох зорилт тавин ажиллаж байна. Монголбанкны гадаад өрийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, алдагдалтай санхүүгийн хэлцэл хийхгүй, санхүүгийн сахилга батыг хангаж ажилласны үр дүнд 2017, 2018 онуудад ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгийг -1.8 их наяд төгрөг болгоод байна. Бидний тооцоогоор одоо баримталж буй зарчим, үйл ажиллагаагаа цаашид хадгалан ажиллавал Монголбанк 2019 болон 2020 онд үргэлжлүүлэн ашигтай ажиллах бөгөөд өөрийн хөрөнгийг эерэг болгохын төлөө ажиллаж байна.

Дөрөвт, Монголбанк гадаад валютын албан нөөцийн хэмжээг 4 дахин нэмэгдүүлж 3.8 тэрбум ам.долларт хүргэж чадлаа. Юуны өмнө төсөв, мөнгөний бодлогын оновчтой хослол нь эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэртэй байдлыг хангах замаар нөөц хуримтлагдахад чухал үүрэг гүйцэтгэснийг онцлох хэрэгтэй. Үүний зэрэгцээ Алт-2 хөтөлбөрт дэмжлэг үзүүлэн ажиллаж, алтны салбарын хууль эрх зүйн орчныг шинэчлэх, алтыг орон нутаг худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, энэ хүрээнд алтны сорьцын лабораторийг байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ. Монголбанк 2016 онд 18.6 тонн, 2017 онд 20 тонн, 2018 онд 22 тонн үнэт металл худалдан авч, энэ эх үүсвэрээс жил бүр 700-800 сая ам.доллараар Монгол Улсын ГВАН-ийг нэмэгдүүлэв. Томоохон

экспортлогч компаниудтай хэлцэл хийх замаар гадаад валютыг худалдан авч, гадаад валютын нөөцийг арвижуулж байна. Мөн дотоодын банкуудын гадаад зах зээлээс санхүүжилт татахад дэмжлэг үзүүлж, гадаад валютын дотогшлох урсгалыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүллээ. Ханшийн сулрах дарамт багатайгаар ГВАН-ийг ийнхүү нэмэгдүүлэх нь амар ажил байгаагүй.

Тавд, Монголбанкны дотоод үйл ажиллагаанд шинэчлэлт хийж, орчин үеийн төв банкны жишигт хүргэхээр ажиллаж байна. Монголбанкны бүтэц, зохион байгуулалтыг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн шинэчилж, хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгон ажиллаа. Үүний зэрэгцээ Монголбанкны ажилтнуудын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлд анхаарч байна. Сүүлийн жилүүдэд хаягдаад байсан Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааг сэргээж, Монгол Улсын эрдэнэсийн сан ном гаргаж, хосгүй үнэт үзвэрээс бүрдсэн музей болгон тохижуулж нийтэд нээлттэй болгох зэрэг олон ажлыг хийж байна.

ОУВС-ИЙН “ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР”-Т МОНГОЛБАНК ХЭРХЭН ОРОЛЦДОГ ВЭ? ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ ЯМАР БАЙНА ВЭ?

Монголбанк энэ хөтөлбөрт орох, орсны дараах үүрэг амлалтаа амжилттай хэрэгжүүлэн эдийн засгийн сэргэлтэд бодит хувь нэмэр оруулж байна. ОУВС-тай урьдчилан зөвшилцөлд хүрч, хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг Сангийн сайд болон Монголбанкны Ерөнхийлөгчийн гарын үсэгтэй 2016 оны 10 дугаар сард, 2017 оны 2

дугаар сард хөтөлбөрт хамрагдах, түүний хүрээнд хийх ажлын үүрэг, амлалт бүхий захиа, хүсэлтийг мөн л гарын үсэг зурж хүргүүлснээр Монгол Улс тус хөтөлбөрт 2017 оны 5 дугаар сард орсон билээ. ОУВС-тай тухайн үед хийсэн уулзалт, хэлцэл маш хүнд байдалд байсныг энд онцлох нь зүйтэй. Тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдлаас харахад ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т орохоос өөр сонголт байгаагүй.

Энэ хөтөлбөрийн хүрээнд Монголбанк мөнгөний бодлого болон банкны салбартай холбоотой зорилт, үүрэг амлалтыг хэрэгжүүлэн, бүх талаар дэмжин ажиллаж байна. ОУВС-гийн ажлын хэсэг 3 сар тутамд Монголд ирж, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж байна. Хөтөлбөрийн хүрээнд тохирсон үүрэг, амлалтыг биелүүлээгүй тохиолдолд хөтөлбөрийн үнэлгээ эцэслэж, ОУВС-гийн захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, эх үүсвэр орж ирэх ажил хойшлоход хүрнэ. ОУВС-гийн шийдвэрийг бусад донор, рейтинг тогтоогч байгууллагууд, хөрөнгө оруулагчид бүгд анхааралтай харж, өөрсдийн шийдвэрээ гаргадаг. Өөрөөр хэлбэл, бусад доноруудын хөтөлбөрийн хүрээнд тохирсон санхүүжилтүүд хойшлоход ч нөлөөлөх үр дагавартай юм. Иймд хөтөлбөрийн хэрэгжилтийг ягштал биелүүлж явах асуудал чухал.

Монголбанк хөтөлбөрийн хүрээнд тохирсон төв банкны дотоод цэвэр активын дээд хязгаар, гадаад цэвэр активын доод хязгаарын тоон зорилтууд болон урьдчилан авах хэмжээнүүдийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн хөтөлбөрийн үнэлгээг амжилттай хийлгэж ирлээ. ГВАН-

ийг нэмэгдүүлэх нь хөтөлбөрийн хүрээнд тохирсон зорилтыг бүрэн ханган хэрэгжүүлэх ажлын нэг хэсэг юм. ГВАН-ийн зорилтыг ханшийн огцом сулралтгүйгээр хангах гэдэг хүндхэн сорилтын дундуур бид явж байна. Хөтөлбөрөөр хүлээсэн үүрэг, зорилтыг биелүүлэхгүй байх нь хөтөлбөр зогсох хүртэл сөрөг үр дагавартай.

Монголбанк тус хөтөлбөрийн хүрээнд банкны салбарт шинэчлэл хийн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүргээ биелүүлэн ажиллаж байна. Арилжааны банкуудыг төлбөрийн чадварыг бодитойгоор тодорхойлох зорилгоор олон улсад нэр хүнд бүхий аудитын компаниар активын чанарын үнэлгээ /AQR/-г бүх банкуудад амжилттай хийлээ. Энэ үнэлгээг Монгол Улс Ази тивийн орнуудаас анх удаа Европын Төв банкны аргачлалын дагуу хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн нь Монголын банкны салбарт болон төв банкны хяналт шалгалтын тогтолцоонд томоохон дэвшил болов. Банкны систем ийнхүү олон улсын стандартын дагуу эрүүл мэндийн үзлэгт орсноор гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагууд, хамтын ажиллагаатай орнуудын итгэлийг хадгалахад чухал. Мөн банкны секторын үйл ажиллагааны стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, банкны системийн эрсдэл даах чадварыг дээшлүүлэхэд авах шаардлагатай арга хэмжээг тодорхойлох, улмаар эдийн засгийн хүндрэлээс богино хугацаанд гарч цаашид тогтвортой санхүүгийн зуучлалыг хадгалж эдийн засгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах банкны тогтолцоог

хөгжүүлэхэд томоохон алхам болов. Активын чанарын үнэлгээний үр дүнд Монголын банкны салбар, систем тогтвортой байна гэсэн дүгнэлт гарав. Харин 1-2 банк дээр асуудал, хүндрэл үүсээд байсныг нийтэд нээлттэй мэдээлсэн билээ. Активын чанарын үнэлгээний болон холбогдох бусад арга хэмжээний үр дүнг үндэслэн Монголбанкнаас хяналт шалгалтын арга хэмжээг авч, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрт орж, тохирсон зорилт, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр эдийн засгийн сэргэж, эдийн засгийн дархлаа сайжирч, гадаадын хөрөнгө оруулагчдын Монголын эдийн засагт итгэх итгэл сэргэж, улмаар дефолтын эрсдэлээс зайлсхийж, хөтөлбөрийн хүрээнд тохирсон зорилтуудаа амжилттай хангаж байна. Хөтөлбөрийн хүрээнд банкны салбарт үргэлжлүүлж хийх ажил ч их байна. Бид холбогдох талуудтай ойлголцож, хөтөлбөрийн хүрээнд тохирсон үүрэг амлалтаа бүрэн хэрэгжүүлж, анхны зорилт, үр дүндээ бүрэн хүрэхийн төлөө байна.

Монголбанк “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай дуусгах ёстой гэсэн байр суурьтай байгаа бөгөөд үүний төлөө зүтгэн ажиллаж байна.

ТАНЫГ МӨНГӨНИЙ ХАТУУ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА ГЭЖ ШҮҮМЖЛЭХ ХЭСЭГ БАЙНА. МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ СУЛРУУЛАХ, МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ТЭЛЭХ БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ ЯМАР БАЙНА ВЭ?

Мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж байна гэж дүгнэх нь олон талаар учир

дутагдалтай. Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд заасан инфляцийн зорилт (8 хувь орчим тогтворжуулах) болон бусад арга хэмжээг авч бүрэн биелүүлж ирлээ. Бид инфляцийг зорилтот түвшинд хангах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх гэхдээ эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж ирлээ. Үүний үр дүнд сүүлийн 3 жилд инфляцийг зорилтыг хангаж, эдийн засгийн өсөлт тасралтгүй нэмэгдсээр өнөөдөр 8.6 хувьтай болж, ажил эрхлэлт нэмэгдээд байна. Ийм үр дүнтэй байгаа бодлого бол хатуу бодлого биш. Энд хэлэхэд олон улсын байгууллагуудын шинжээчид бидний баримталж ирсэн бодлогыг сул талдаа байсан гэж үзэх гээд байдаг тал бий. Харин бид Монголын эдийн засгийн онцлог, сэргэлтийг дэмжих нөхцөл шаардлага зэргийг сайтар тайлбарлаж, ойлголцож, бодлогоо амжилттай хэрэгжүүлсний дүнд өнөөдрийн эдийн засгийн сэргэлт, үр дүн гараад байна.

Бидэнд хийх ажил их, тулгарч буй сорилтууд том байна. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хүлээсэн үүрэг амлалтаа Монгол Улс биелүүлэх хүрээнд “зайлшгүй хэрэгжүүлэх ёстой” арга хэмжээнүүдэд улс төрийн болон олон нийтийн дэмжлэгтэй явж ирлээ. Монгол Улсын нийтлэг эрх ашгийн төлөө, дунд хугацааны тогтвортой байдлын төлөө авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд дэмжлэг, зөвшилцөл дунд амжилттай хэрэгжиж байна. Төв банк мөнгөний нийлүүлэлтийг ‘механик’-аар, төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар нэмэгдүүлээд явдаг байдлыг дахин гаргахгүй

гээд хөтөлбөрт нэгдэн орсон баримт бичиг дээр Сангийн сайдын болон миний гарын үсэг байгаа. Нөгөө талдаа, ‘миний гар, хөл хүлээстэй байна’. Өмнөх жилүүдэд Монголбанк, Монголбанкны Ерөнхийлөгчийн дангаар бие даан шийдэж болдог байсан олон асуудлууд өнөөдөр хөтөлбөрийн хүрээнд олон улсын байгууллагууд, доноруудын өмнө хүлээсэн үүрэг, амлалтаар хязгаарлагдаж байна. Төсвийн шинжтэй үйл ажиллагааг Монголбанк дахин эрхлэхгүй байх, мөнгөний бодлогын шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч дангаар бус Мөнгөний бодлогын хорооны хамтын шийдвэрээр гаргах зэрэг олон амлалт, зохицуулалтууд бий болоод байна.

Миний итгэл үнэмшил бол Мөнгөний бодлогыг одоогийн түвшнээс сул байдлаар хэрэгжүүлэх нь инфляци, ханшийн сулралт, улмаар ГВАН хуримтлагдахгүй байх, улмаар эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдал сөрөг үр дагавартай байхаар байна. Бид урагшаа харж, улс орны эрх ашгийг эрхэмлэж, дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалахын төлөө бодлого, шийдвэрээ гарган хэрэгжүүлж байна.

ТА ЭДИЙН ЗАСГИЙН ЦААШДЫН ТӨЛӨВ, СОРИЛТУУДЫГ ХЭРХЭН ХАРЖ БАЙНА ВЭ?

Эдийн засгийн цаашдын төлөв байдлыг авч үзвэл эдийн засгийн сэргэлт үргэлжилж, өсөлт 2018 оны түвшнээс буурахгүй байх, инфляци зорилтот түвшний орчим байхаар хүлээгдэж байгаа. Гэхдээ эдийн засагт томоохон сорилтууд тулгарсан хэвээр, бидэнд хийх ажил их байна. Тухайлбал, Монгол Улс 2020-2024

оны хооронд төр болон хувийн хэвшлийн томоохон дүнтэй гадаад өр, төлбөрийг барагдуулахад ГВАН-өөс 4 дахин давсан гадаад валют шаардагдах урьдчилсан тооцоо гарч байна. Энэхүү өр, төлбөрийг дефолтоос зайлсхийж, амжилттай шийдвэрлэх сорилт нь дан ганц Монголбанкны бус, Монголчууд бидний шандас шөрмөсийг шалгах болно. Энэ сорилтыг даван гарахын тулд өнөөдрийн бидний хийх ёстой эн тэргүүний зүйл бол ГВАН-ийг нэмэгдүүлэх явдал.

Монгол Улс олон улсын санхүүгийн байгууллагууд, донорууд болон гадаадын хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд доноруудын өмнө хүлээсэн зарим үүрэг амлалт нь богино хугацаандаа ‘өвдөлт’ мэдрүүлэхээр байсан хэдий ч дунд, урт хугацаатай ‘эрүүл, чийрэг’ болгоход тус дэмтэй билээ. Үүрэг, амлалтаа амжилттай хэрэгжүүлж, цаашид ‘нэр нүүртэй’ хамтран ажиллах нь Монгол Улсын гадаад өрийн тогтвортой байдлыг дунд хугацаанд үргэлжлүүлэн хангах, тэдний дэмжлэгийг авч тулгарч буй сорилтыг хамтдаа амжилттай даван туулахад стратегийн чухал ач холбогдолтой. Иймд хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэх нь чухал байна.

Монгол Улс Мөнгө угаахтай тэмцэх, санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-ын “өндөр эрсдэлтэй болон хамтран ажилладаггүй улс” гэсэн ангилал буюу “хар саарал жагсаалтад” орох эрсдэл өндөр хэвээр байна. Үр дагаварт нь бид санхүүгийн гүйлгээний хувьд

‘хаалттай’ нөхцөл байдалд орно. Иймд дан ганц Монголбанкнаас гадна Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл зэрэг хууль, хүчний байгууллагууд энэ асуудалд онцгой анхаарч, нягт хамтран ажиллаж энэ сорилтыг амжилттай даван туулах шаардлагатай байна.

Дэлхийн худалдааны дайн бодитоор бий болж байгаагаас глобал зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэл өндөр байна. “Үүлэн чөлөөний нар”-тай байгаа дээр ‘байшингийнхаа дээврийг засах’ буюу дунд хугацааны сорилтуудыг даван туулах бэлтгэл ажлуудыг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, дархлааг бэхжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Тухайлбал, гадаад валютын нөөцийг цаашид нэмэгдүүлэх, тогтвортой өсөлтөд чиглэсэн харилцан хосолсон макро бодлогыг хэрэгжүүлэх, төсвийн сахилга батыг чандлан сахих, эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгох, банк, санхүүгийн салбарын эрүүл мэнд, эрсдэл даах чадварыг сайжруулах, банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, гадны хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих, томоохон төсөл хөтөлбөрүүдийг тогтвортой хэрэгжүүлэх, уул уурхайгаас бусад экспортын чиг баримжаатай салбаруудыг дэмжих, гадаад худалдааг хөнгөвчлөх, дэмжих цогц бодлого хэрэгжүүлэх, гадаад өрийн тогтвортой байдлыг хангах, оновчтой бүтцийг бий болгох

шаардлага өндөр хэвээр байна.

МОНГОЛБАНКНЫ ХУВЬД ОЙРЫН ХУГАЦААНД ЮУН ДЭЭР ИЛҮҮТЭЙ АНХААРЧ АЖИЛЛАХ ВЭ?

Монголбанк Монгол Улсын эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтийг бататгах, эдийн засгийн өсөлтийг нийт ард иргэд, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй болгох, үндсэн чиг үүргээ амжилттай үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, өмнө тулгарч буй сорилтуудыг амжилттай даван туулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг эрх бүхий байгууллагуудтай хамтран цаг тухайд нь авч хэрэгжүүлнэ.

Төв банкны нээлттэй, ил тод болон бие даасан, хариуцлагатай байх зарчмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд эдийн засгийн тогтвортой байдал, ирээдүйн өсөлт хөгжлийн чухал тулгуур болсон реформ, шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх ажлыг цаашид үргэлжлүүлэх болно.

БАЯРЛАЛАА.



Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах – инфляцийн зорилтот түвшинг хангах.

1



Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах.

2



Төсвийн сахилгыг хангах, макро бодлогын уялдааг сайжруулах.

3



Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх.

4



Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний сувгийн нөлөөг сайжруулах.

5



Санхүүгийн салбарын долларжилтыг бууруулах.

6



Санхүүгийн хүчтэй тогтолцоотой болох, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх.

7



Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх.

8



Зээлийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

9



Банкны үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх.

10



Төрийн болон банк, санхүүгийн байгууллагын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.

11



Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх.

Хадгаламж, зээлийн хүү өндөр байгаагийн макро суурь шалтгаан олон байна. Иймд зээлийн хүү буурах макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэхэд чиглэсэн харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлнэ.



Мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөөг сайжруулах.

Эдийн засаг дахь хүүний сөрөнхий түвшин, өөрчлөлтийн чиглэлийг мөнгөний бодлогын хүү тодорхойлох учиртай. Гэвч бодлогын хүүний дамжих нөлөө сул байгаа учраас бодлогын хүүний нөлөөг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



Банкны эрсдэл удирлах чадвар, үр ашгийг, засаглалыг сайжруулах.

Хадгаламж, зээлийн хүү өндөр байхад макро хүчин зүйлээс гадна микро хүчин зүйлд, банкны үйл хөдлөл нөлөөлж байна. Ялангуяа банк үйл ажиллагааныхаа зардлыг бууруулж, үр ашгаа нэмэгдүүлэх, засаглал сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС (2019.06.19)

Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг танилцуулах хэвлэлийн бага хурал 2019.06.19 нд болж, Мөнгөний бодлогын хорооны мэдэгдлийг танилцуулж, мөн Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний талаар сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариуллаа.

БЛҮҮМБЭРГ ТВ: Гуравдугаар сард мөнгөний бодлогын мэдэгдэлд бодлогын хүүг өсгөж магадгүй гэсэн мессежийг өгсөн. Энэ удаад хэвээр хадгалах шийдвэр гаргасан байна. Гэтэл Улаанбаатар хотын инфляц хамгийн сүүлийн байдлаар 8.8 хувьд хүрсэн. Ийм үед бодлогын хүүг өсгөхгүй байх шалтгаан юу байсан талаар товчхон тайлбарлана уу?

Мөнгөний бодлогын газрын захирал **Б.БАЯРДАВАА:**

Улаанбаатар хотын инфляц 8.8 хувьтай гарсан нь 5 дугаар сарын үнийн өсөлтөөр тайлбарлагдана. Энэхүү өсөлтийг голлон тайлбарлаж байгаа зүйл нь махны үнэ. Махны үнэ өөрөө зөвхөн тавдугаар сард 10.8 хувиар өссөн. Жилийн дүнгээрээ 26 хувиар өссөн. Махны үнийн өсөлт нийт 8.8 хувийн инфляцийн 2.4 нэгж хувийг дангаараа тайлбарлаж байгаа. Бензиний үнэ 0.7 хувийг, дөрөв, тавдугаар сард 0.7 нэгж хувийг бүрдүүллээ. Бензин, шатахууны үнэ дөрөв, тавдугаар сард 170-180 төгрөгөөр өссөн нь нийлүүлэлтийн шинжтэй инфляцийг нэмэгдүүлсэн. Хатуу түлшний үнэ 0.9 нэгж хувийг бүрдүүлсэн. Тэгэхээр, 8.8 хувийн инфляцийн 4 хувь нь дээрх гурван бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой. Хоёрдугаарт, өмнөх мөнгөний бодлогын хурал дээр бодлогын хүүг нэмэгдүүлж болзошгүй гэж мэдэгдсэн. Гэхдээ энэ удаад бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Яагаад гэвэл гадаад эдийн засгийн нөхцөл байдлыг харвал тодорхой бус байдал нэмэгдсэн байна. Хэрвээ та бүхэн санаж байгаа бол 2018 оны 10, 11 дүгээр сарын орчимд мэргэжилтнүүдийн

санаа зовж байсан асуудлууд 1019 оны нэгдүгээр сард нэлээд сайн зүг рүүгээ эргэсэн байсан. Ялангуяа, худалдааны маргаантай холбоотойгоор тарифыг нэмэгдүүлэх асуудал 90 хоногоор хойшилсон нь нэлээд таатай нөхцөл байдлыг бий болгож, хүлээлт сайжирсан. Зарим тохиолдолд эдийн засгийн өсөлтийн төлөвийг сайжруулах төсөөллүүдийг ч хийж байсан. Харин тавдугаар сараас нөхцөл байдал нэлээд хүндрэлтэй, савлагаатай болчихсон. Тэгэхээр гадаад нөхцөл байдал цаашдаа яаж тогтворжихыг бид харах шаардлагатай. Нөгөө талаас, Осакад болох "Их 20"-ын уулзалтын үеэр хоёр ерөнхийлөгчийн уулзах хэлэлцээрүүдийг хийж эхэлсэн байна. Үүнийг урьтаад хоёр талын багууд урьдчилж уулзалтууд хийгдэхээр болсон байна. Энэ мэдээллийг дагаад хөрөнгийн зах зээлийн индексүүдэд өнөөдөр өглөөнөөс ногоон гэрлүүд асч эхэлсэн байгаа. Үүнээс гадна "Их 7"-ийн уулзалт Парист ирэх наймдугаар сард болно. Энэ уулзалтуудаас тодорхой хэмжээний хүлээлт үүсгэхээр байна.

Дотоод талдаа бол энэ онд төсвийн хөрөнгө оруулалт нэлээд нэмэгдсэн. Энэ нь бидний хувьд мөнгөний бодлогын хүүг нэмэгдүүлэх нөлөөллийг үзүүлж байсан. Эхний улирлын байдлаар төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл маш бага хувьтай байсан. Дөрөв, тавдугаар сарын байдлаар мөн л дутуу гүйцэтгэлтэй байгаа. Эдийн засаг руу төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх мөнгө тодорхой хэмжээгээр хойшилж, саарч байгаа учраас дарамт харьцангуй багасч байгаа. Гэхдээ оны эцэс рүү төсвийн хөрөнгө оруулалт эрс нэмэгдэнэ гэсэн

хүлээлттэй байна. Хоёрдугаарт, хэрэглээний зээлийн өсөлт нэлээд эрчимтэй саарч байна. 55 хувиас 33 хувь руу орж ирж байгаа нь хэрэглээгээр дамжсан инфляцийн дарамтыг бууруулж байна. Нөгөө талдаа цалингийн өсөлт инфляцид үзүүлэх дарамт нь бидний нэгдүгээр улиралд төсөөлж байснаас арай бага байх төлөвтэй байна. Түүнчлэн нийлүүлэлт талаасаа төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ нэлээд эртнээс нэмэгдэх хүлээлттэй байсан ч харьцангуй хойшилж, аажмаар нэмэгдэж байгаа нь инфляцийн дарамтыг бууруулж байна. Дээр нь бензиний үнэ дөрөвдүгээр сарын дундуур тавдугаар сарын эхээр дэлхийн зах зээл дээр 70 гаруй ам.доллар болж нэмэгдсэн. Одоо эргэж буураад, 62 орчим ам.доллар байна. Энэ талаас нь харвал бензиний үнэ, түүний хоёр дахь үеийн нөлөөгөөр орж ирэх инфляцийн дарамтын нөлөө бага зэрэг сулрах болов уу гэж харж байгаа. Энэ нөхцөл байдлуудаас үндэслээд мөнгөний бодлогын хүүг чангаруулж болзошгүй гэж мэдэгдэж байсан хэдий ч энэ удаад хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзсэн.

Дэд Ерөнхийлөгч **Б.ЛХАГВАСҮРЭН:**

Үүн дээр нэмж хэлэхэд, улирал бүрийн эхэнд төв банкуудын мөнгөний бодлогын хороо хуралдаж, шийдвэрээ гаргадаг. Биднийг нэгдүгээр улиралд мөнгөний бодлогын хороогоо хуралдуулж, шийдвэрээ гаргаж байх үед Америкийн төв банк бодлогынхоо хүүг 2-оос нэмэгдүүлж, цаашлаад энэ оны туршид 2 ч удаа нэмэгдүүлж болзошгүй гэдэг зүйл яригдаж байсан. Гэтэл сүүлд авч байгаа мэдээллээр өсгөхгүй байхаар шийдсэн гэх зэрэг өөрчлөлт байгаа юм. Монголбанкны хувьд төгрөгийн ханшийг анхаарч авч үздэг учраас өрсөлдөж байгаа мөнгө маань цаашид ханш нь чангарахгүй, хүүгээ өсгөх дарамт учрахгүй нь гэдэг нөлөөлөл гарч ирсэн. Тэр ч утгаараа бодлогын хүүг хэвээр хадгалсан. Мөн бусад олонх улс орны төв банкууд бодлогын хүүгээ хэвээр хадгалах, харзнах шийдвэр гаргасан байгаа.

Энэ удаагийн мөнгөний бодлогын мэдэгдэлд “Төв банкны бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлэх нь чухал” гэж дурдсан байна. Яагаад энэ үед энэ асуудал чухлаар хөндөгдөж байгаа талаар нэмэлт мэдээлэл авъя.

МБХ-ны Хараат бус гишүүн **Ц.БАТСҮХ:**

Та бүхний мэдэж байгаагчлан эдийн засаг байнга хэлбэлзэж байдаг. Хэлбэлзлийн шалтгааныг олон янзаар тайлбарладаг. Нэгдүгээрт, эрэлтийн буюу худалдан

авалттай холбоотой, хоёрдугаарт нийлүүлэлтийн буюу технологи, үйлдвэрлэлийн шинж чанартай нөлөөллүүд бий. Эдгээрээс гадна богино хугацаатай эдийн засгийн хэлбэлзэлд маш хүчтэй нөлөөлдөг нэг хүчин зүйл нь улс төрийн шалтгаантай нөлөөлөл юм. Тэрний нэг нь сонгуулийн жилийн эффект гэгдэх нөлөө юм. Энэхүү нөлөөлөл нь голчлон сангийн тэлэх бодлогоор дамжин цалин өсгөх, эсвэл янз бүрийн хөтөлбөрүүдийг асар хурдтайгаар хэрэгжүүлдэг. Энэ нь эдийн засгийг тэлэх нөлөөлөл үзүүлж, бидний зорьж буй инфляцийг тогтвортой байлгахад маш хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгодог. Энэ хүндрэлтэй байдал дээр нэмэгдээд төв банк төсвийн шинжтэй арга хэмжээнд оролцвол санхүүгийн үе хоорондын маш хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгодог. Ийм тохиолдолд хамгийн гол нэг хазаар нь төв банкны бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлэх буюу төв банк төсвийн шинжтэй арга хэмжээнд оролцохгүй байх нөхцөл юм. Төв банк сангийн бодлогоос үл хамааран эдийн засгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх гэсэн байр суурь юм. Энэхүү байр суурь нь цаашдаа Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах гэсэн асуудалтай холбоотой юм. Тэгэхээр төв банкны хараат бус байдлыг хангах гэдэг нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах гэсэнтэй утга нэг юм.

2020 онд Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн хугацаа дуусна. Үүний эргэн төлөлт хийх төлөвлөгөө ямар байгаа вэ?

2017 оны 7 дугаар сард Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийг 3 жилээр сунгах хэлэлцээрт хүрсэн. Энэхүү хугацаа 2020 оны 7 дугаар сард дуусна. Монголбанкны зүгээс своп хэлцлийн хугацааг гадаад валютын нөөц, ханшид дарамт багатайгаар цааш дахин сунгах талаар Хятадын ардын банктай хэлэлцээр хийж байгаа.

ИЙГЛ ТВ: Ханштай холбоотойгоор асуух зүйл байна. Ам.долларын ханш 2600 орчим төгрөг дээр тогтвортой байна. Гэтэл төлбөрийн тэнцэл эерэг, хөрөнгө оруулалт ч бас боломжийн байгаа шүү дээ. Төгрөгийн ханш яагаад чангарахгүй байна вэ, Монголбанкны зүгээс ханшийн талаар ямар бодлого баримталж байна вэ?

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал **А.ЭНХЖИН**

Монгол Улс гадаад эдийн засгийн орчноос маш их хамааралтай, цөөхөн тооны түүхий эдээс хамааралтай. Манайх шиг улсын хувьд гадаад валютын ханш нь гадаад орчны эрсдэлийг бууруулах, тэнцвэрийг хадгалахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа валютын ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн, уян хатан тогтоно гэдгийг төв банкны тухай хуульд хуульчилж өгсөн. Монголбанкны зүгээс түр зуурын эрэлт, нийлүүлэлтийн шалтгаантайгаар дотоодын зах зээл дээр савлагаа үүсэхээс сэргийлж, валютын захад оролцдог. Энэ он гарснаас хойш Монголбанк валютын захад 1 тэрбум гаруй ам.долларыг нийлүүлээд байна. Он гарснаас хойш төгрөгийн ханш ам.долларын эсрэг тогтвортой байгаа. Энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар төлбөрийн тэнцэл 320 гаруй сая ам.долларын ашигтай гарсан. Энэ онд төлбөрийн тэнцэл ашигтай гарна гэсэн хүлээлттэй байгаа. Энэ утгаараа ханш тогтвортой байна гэсэн хүлээлттэй байна. Гэхдээ нэг эрсдэл байгаа нь том гүрнүүдийн худалдааны дайнтай холбоотойгоор гадаад зах зээл дэх тодорхой бус байдал нэмэгдэж, манай экспортын гол гол түүхий эдийн үнэд нөлөөлж эхэлсэн. Энэ нөлөөлөл нэмэгдэж, манай экспортын орлогод, цаашлаад гадаадын хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлбөл, төгрөгийн ханш унаж болзошгүй эрсдэл бий. Өнөөдрийн мөнгөний бодлогын шийдвэр нь энэхүү эрсдэлийг ч бас харж, тооцоолсон гэдгийг хэлье.

Гэхдээ Монголбанк ханшийг хариуцах ёстой гэсэн шүүмжлэл бий. Сүүлийн 15-16 жилийн түүхийг харвал төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3 удаа л чангарч байсан. 2006 онд төсөв, төлбөрийн тэнцэл ашигтай гарахад чангарч байсан. 2010 онд Оюутолгойн хөрөнгө оруулалт орж ирэхэд нэг чангарсан. 2017 онд Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үед чангарсан. Бусад хугацаанд төгрөгийн ханш ам.долларын эсрэг ерөнхийдөө л суларч ирсэн. Энэ нь юуг харуулж байна вэ гэхээр ханш нь манай эдийн засгийн бүтэцтэй холбоотой. Эдийн засаг төрөлжөөгүй, цөөхөн тооны түүхий эдээс хамааралтай байгаа нь ханшийг чанга байлгах боломжийг олгохгүй байна гэсэн үг. Зөвхөн эдийн засгийн бүтцээс гадна улс төрийн тогтворгүй байдал ханшид хүчтэй нөлөөлдөг. Монгол Улсын хувьд төлбөрийн тэнцлийн урсгал данс үргэлж алдагдалтай байдаг. Энэхүү алдагдлыг гадаадын хөрөнгө оруулалтаар л нөхдөг. Гадаад хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгах хөшүүрэг, тогтвортой эрх зүйн орчин, улс төрийн таатай нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Тэгэхээр төгрөгийн

ханш сулраад байна гэдэг асуудлыг зөвхөн Монголбанк руу бус Засгийн газар, улстөрчдөд ч бас тавих хэрэгтэй. Төв банкны зүгээс ханшийн түр зуурын шинжтэй савлагааг бууруулахын тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг аваад явж байна.

Ипотекийн зээлийн санхүүжилт хэвийн олгогдож байгаа юу. Шинэ журам хэрэгжиж эхлээд, санхүүжилт нэмэгдсэнээс хойш ямар үр дүн гарч байгаа вэ. Цаашдаа эх үүсвэрийг дахин нэмэгдүүлэх боломжтой юу?

Монголбанкны хувьд ипотекийн хөтөлбөрийг хэрэгжүүлээд явж байна. 2018 онд Засгийн газар, Монголбанкны зүгээс 4500 орчим иргэнд ипотекийн зээлийн санхүүжилтийг олгосон. Эдийн засгийн байнгын хорооны 35 дугаар тогтоолын дагуу Засгийн газар болон Монголбанкны эх үүсвэрийн хүүг 1 хувь болгож бууруулах чиглэл өгсөн. Монголбанкнаас энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж, эх үүсвэрийн хүү буурсантай холбоотойгоор арилжааны банкуудын эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр маш их ажлыг хийсэн. Ипотекийн хөтөлбөрийг Монголбанк л хэрэгжүүлдэг юм шиг харагддаг боловч үүний цаана МИК, хөтөлбөрт оролцож байгаа 11 банк, энэ бүхнийг зохицуулж буй журам, зааварт өөрчлөлт оруулах зэрэг маш их ажлыг хийснээр энэ оны дөрөвдүгээр сараас эхлэн Монголбанк, арилжааны банкны эх үүсвэрээс санхүүжилтийг олгож эхэллээ. Ингэснээр санхүүжилтийн хэмжээ бараг 50 орчим хувиар нэмэгдээд байна. Он гарснаас хойш тавдугаар сарын байдлаар бид 164 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ипотекийн зээлийн санхүүжилтэд олгоод байна. Өмнөх онтой харьцуулахад санхүүжилтийн хэмжээ 50 хувиар, зээл авсан иргэдийн тоо өмнөх онтой харьцуулахад 2.4 дахин нэмэгдээд байна. Зургаадугаар сарын хувьд бид нийт 3 эх үүсвэрээс нийтдээ 48 тэрбум төгрөгийг, үүнээс цааш сар бүр 36 тэрбум төгрөг гэхээр энэ онд нийтдээ 430 орчим тэрбум төгрөгийн 8 хувийн хөтөлбөрт олгохоор зорьж ажиллаж байна. Үүн дээр нэг зүйлийг нэмж хэлэхэд анх ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт ороход төв банк төсвийн шинж чанартай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх нь зохисгүй гэж үзсэн. Тийм учраас Монголбанкинд ипотекийн хөтөлбөрөөс гарах шаардлагыг тавьж байсан. Монголбанкны зүгээс ОУВС-тай нэлээд олон удаагийн хэлэлцээр хийж, 2020 оны нэгдүгээр сарын 1-нээс ипотекийн хөтөлбөрөөс гарах шийдэлд хүрсэн. Тэгэхээр 2020 оны нэгдүгээр сарын 1-нээс хөтөлбөрийн бүх санхүүжилт Засгийн

газарт шилжинэ. Ирэх оны төсвийг хэлэлцэж байгаа энэ үед ипотекийн хөтөлбөрийн санхүүжилтийг улсын төсөвт суулгах талаас нь УИХ-ын гишүүд, ЗГ ажиллах шаардлагатай байгаа.

ОУВС-ийн төлөөлөгчид хүрэлцэн ирсэн, уулзалт хийгээд явж байгаа. Зургаадугаар шатны үнэлгээ батлагдахгүй байгаа гол шалтгаан юу байна вэ? Ямар яриа хэлэлцээрүүд явагдаж, ямар ойлголцолд хүрэх шаардлагатай байгаа вэ?

Дэд Ерөнхийлөгч **Б.ЛХАГВАСҮРЭН:**

ОУВС-ийн төлөөлөгчид хүрэлцэн ирсэн. Тэд бол үнэлгээний багийнхан биш, өөр зорилгоор ирсэн. Монгол Улс ОУВС-ийн гишүүн орон. ОУВС-ийн зүгээс гишүүн орнууддаа байнгын, өөрийнхөө дүрмийн дагуу шалгалт хийдэг. Үүнийг "Артикл-4" гэдэг. Монгол Улс ОУВС-ийн гишүүн орны хувьд дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байна уу гэдэгт үнэлгээ өгөх зорилготой юм. Энэ үнэлгээг улс болгонд хийдэг. АНУ-д саяхан хийгдсэн. Удахгүй ОУВС-ийн захирлуудын зөвлөлөөр АНУ-д хийгдсэн шалгалтын үр дүнг хэлэлцэх гэж байгаа. Монгол Улсад ч бас энэ дагуу шалгалт хийгдэж байна. Тэгэхээр өртгөсөн санхүүжилтийн хөтөлбөртэй холбоотой үнэлгээний асуудал биш гэдгийг хэлэх гэсэн юм.

Хөтөлбөрийн ээлжит үнэлгээг хийх асуудал яагаад хойшлогдоод байгаа юм бол?

Дэд Ерөнхийлөгч **Б.ЛХАГВАСҮРЭН:**

Монголбанк сэтгүүлчид та бүхэнд байнга, нээлттэй мэдээллийг өгч байгаа. ОУВС-тай хамтраад хөтөлбөр хэрэгжүүлж эхлээд, бараг хоёр жил болчихлоо. 2020 оны тавдугаар сард дуусах, гурван жилийн хугацаатай хөтөлбөр. Улирал болгон үнэлгээ хийгээд, тодорхой хэмжээний санхүүжилтүүд орж ирж байгаа. Хөтөлбөрийн хүрээнд банкны секторт активын чанарын үнэлгээ хийгдсэн. Үнэлгээний дүнгээр банкны секторт тодорхой хэмжээний өөрийн хөрөнгө нэмэгдүүлэх шаардлага гарсан. Улмаар банкуудад 2018 оны төгсгөл хүртэл өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх хугацаа олгосон. Энэ хугацаанд багтаж, банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн. Нэмэгдүүлсэн эх үүсвэр нь өөрөө яг хуулийн дагуу байна уу, үгүй юу гэдэг дээр нэмэлт тодруулга хийе гэсэн. Энэ дагуу хөндлөнгийн үнэлгээний компаниар хийлгэе гэж тохирсон байгаа. Ингэж, нэмэлт ажил гарсантай холбогдуулаад, үнэлгээ удааширч байгаа тал бий. Түүнээс биш юу ч хийгдээгүй, эсвэл огт болохгүй болчихсон зүйл байхгүйг хэлье.

Эх үүсвэрийг тодруулах, хөндлөнгийн компанийг тодруулах, ажлыг гүйцэтгэх хугацааны тухайд?

Үнэлгээний компаниа тодруулаад, ажлаа гүйцэтгэж, дуусах хүртэл хоёр сарын хугацаа бий. Тэгэхээр наймдугаар сарын сүүлээр үр дүн гарна.

НУСЗЗГ-ын захирал **А.ЭНХЖИН:**

Дэд Ерөнхийлөгчийн хэлсэн дээр нэмж хэлэхэд, ОУВС-ийн хөтөлбөр ямар нэгэн байдлаар саатаагүй. Наймдугаар сарын сүүл гэхэд банкуудын эх үүсвэрийг шалгах ажил дуусаад, үнэлгээ хийгдэнэ. Гэхдээ Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр нь зөвхөн ОУВС-ийн хөтөлбөр биш. Дэлхийн банк, Жайка, Японы Засгийн газар, АХБ зэрэг олон байгууллага оролцож байгаа. Тэгэхээр бусад хөтөлбөрт оролцогч байгууллагуудтай хэлэлцээр хийж, санхүүжилтийг авах ажлыг бид аль хэдийнэ эхлүүлээд байна. Дэлхийн банктай хоёр дахь шатны санхүүжилтийг авах хэлэлцээрийг эхлүүлсэн. Бусад санхүүжилтүүдийг авах асуудал ОУВС-аас 100 хувь хамаарахгүй юм.

UBS TV: Капитал банкны хувьд тус банкны зориудаар, улс төрийн шалтгаанаар дампууруулсан гэх хардлага яваад байна. Энэ талаар тайлбар өгнө үү?

Хяналт шалгалтын газрын захирал **Н.БАТСАЙХАН:**

Капитал банк төлбөрийн чадварын хүндрэлд орсон. Үүнээс өмнө Монголбанкнаас шат дараатай, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүрт нь авч хэрэгжүүлсэн. Илэрсэн зөрчил бүр дээр нь бас өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхэд нь хугацаатай үүрэг даалгаваруудыг өгсөн. Капитал банкны хувьд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх болон бусад хугацаатай үүрэг даалгаваруудыг тухай бүрт нь биелүүлж чадаагүй. Улмаар санхүүгийн нөхцөл байдал нь улам хүндэрсэн тул Монголбанк хуулийн дагуу арга хэмжээ авсан. Үүнд ямар нэгэн улс төрийн шалтгаан байхгүй.

ТВ8: Капитал банкны араас дахин нэг банк хүнд байдалд орсон гэх мэдээлэл байна. Энэ талаар тодорхой хариулт өгөхийг хүсье.

Монголбанк банкуудад хуулийн хүрээнд шаардлага тавьж ажилладаг. Банк бол итгэлцэл дээр үндэслэсэн бизнесийн байгууллага юм. Тийм учраас Монголбанк хянан, зохицуулагч байгууллагын хувьд энэ банк ийм байгаа гэсэн мэдээллийг өгөх нь зохисгүй. Банкны тухай хуульд заасан шаардлагуудыг бүх банкинд ижил тэгшээр тавьж, хянаж ажилладаг. Банкны тухай

хууль болон Монголбанкнаас баталсан холбогдох дүрэм, журмуудыг зөрчсөн тохиолдолд Монголбанк шаардлагатай арга хэмжээг нь авдаг.

ИЙГЛ ТВ: Зээлийн хүүг бууруулах сонирхол байгаа ч тодорхой алхам хийгдэхгүй байна гэсэн шүүмж бий. Хэрвээ зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоовол юу болох вэ?

Монголбанкны Ерөнхий эдийн засагч **Д.ГАН-ОЧИР:**

Монголбанкны байр суурь маш тодорхой байгаа. Зээлийн хүүнд дээд хязгаар тогтоох нь санхүүгийн зуучлалд сөрөг үр дагавар үзүүлнэ. Ялангуяа, өнөөдрийн яригдаж байгаа шиг 18 хувь ч юм уу, хэт доогуур тогтоох нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, зарим төрлийн хэрэглээний зээл шаардлагатай байгаа өрхүүдэд анхны зорьсноосоо эсрэг үр дүнг авчрах эрсдэл байна гэдэг судалгаа, тооцоог гаргаж байгаа. Харин мөнгө хүүлэлттэй тэмцэх тухайд Монголбанк Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүдтэй хамтраад, боловсруулж байгаа. Үүн дээр тодорхой зохицуулалтуудыг тусгаж, оруулаад байна. Зээлийн хүү өнөөдрийн Монголын эдийн засагт голлох асуудлуудын нэг болоод байна. Үүнтэй холбоотой Монголбанк ямар байр суурьтай байна вэ гэдгийг нэгтгэж хэлье.

Зээлийн хүү өнгөрсөн оны төгсгөлд дунджаар 18.9 хувьтай байгаа нь сүүлийн зургаан жилийн доод түвшин болоод байна. Үүнд төсөв, мөнгөний бодлогын харилцан хосолсон, үр дүнтэй бодлого нөлөөлсөн гэж үзэж байгаа. Мөн банкуудын эх үүсвэрийн хүү 10.5 хувьд хүрсэн. Үүнд өнгөрсөн оны туршид бодлогын хүү 10 хувьд буюу доогуур түвшинд хадгалагдсан нь чухал нөлөө үзүүлсэн. Энэ оны статистикаар зээлийн хүү бага зэрэг өссөн. Тодруулбал, 17.4-17.6 орчим хувь дээр хэлбэлзэж байна. Үүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байгаа. Юун түрүүнд бодлогын хүү 10 хувьд хадгалах нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, валютын ханш, инфляцийн дарамтыг зохицуулахад хэт бага түвшинд байна гэж үзсэн учраас бодлогын хүүг өнгөрсөн оны төгсгөлд 1 нэгж хувиар өсгөж, 11 хувьд хүргэсэн. Энэхүү өсөлт зээл, хадгаламжийн хүүнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Нөгөө талаас банкны салбарт буй үйл ажиллагааны зардлын өсөлт, чанаргүй зээлийн өсөлт сүүлийн саруудад өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь зээлийн хүүний одоогийн түвшинд нөлөөлж байгаа. Гэхдээ бидний харж байгаагаар бодлогын хүү 11 хувь, инфляци

зорилтот түвшин байх нөхцөлд зээлийн хүү одоогийн түвшнээс төдийлөн өсөхгүй, тогтвортой байна.


Мөнгөний бодлогын төлөвийг үүнээс бага болгож, бууруулах боломжгүй гэдгийг манай газрын захирлууд өмнө нь хэлсэн. Гэхдээ цаашдаа эдийн засгийн тогтворжилт бий болвол бодлогын хүүг бууруулж болно. Мөн дагаад зээлийн хүү буурч болдгийг бид бүхэн харсан учраас зээлийн хүүг зах зээлийнхээ зарчмаар макро эдийн засгийн суурь хүчин зүйлтэй нийцтэйгээр бууруулах боломжтой гэж үзэж байгаа.

УИХ-ын дарга мөнгөний зөөлөн бодлого баримталж, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ёстой гэж байр сууриа илэрхийлсэн. Үүн дээр Монголбанк ямар байр суурьтай байгаа вэ. Ер нь өнгөрсөн хугацаанд баримталж ирсэн мөнгөний бодлогын үр дүн ямар байна вэ?


МБХ-ны хараат бус гишүүн **Ц.БАТСҮХ:**

Мөнгөний бодлогын хорооноос өнгөрсөн хугацаанд гаргасан шийдвэрүүдийг харвал нэгдүгээрт мөнгөний бодлогын хүүг өсгөх, бууруулах, хоёрдугаарт макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг хэрэгжүүлж байна. Макро зохистой бодлогын арга хэмжээнүүд үр дүнгээ өгч, хэрэглээний зээлийн өсөлтийн хэмжээ 55 хувиас 33 хувьд хүрч буурсан байна. Энэ нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд үр дүнгээ өгч байна. Хоёрдугаарт, мөнгөний бодлогын шийдвэрүүд нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой. Энэ хүрээнд банкуудын бизнесийн зээлийн өсөлт нэмэгдсэн, түүнчлэн гадаад өр, макро эдийн засгийн байдал тогтворжиход эергээр нөлөөлсөн үр дүнг үзүүллээ. Мөнгөний бодлогын арга хэмжээ нь дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэгдэж байна. 2020-2024 онд 14.5 тэрбум ам.доллар авна гэдэг ирэх 5 жилийн төлөвийг харж, өнөөдрийн бодлогын арга хэмжээг авч байгаа юм.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц



Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



- M2 мөнгөний жилийн өсөлт 19.1% -д хүрч 20.3 их наяд ₮-т хүрэв.
- Өмнөх сараас 2%-иар буюу 390.9 тэрбум ₮-өөр өсөв.
- Үүнээс M1 мөнгө 3.4% (125.7 тэрбум ₮) –нар, бусад хадгаламж 1.6% (265.4 тэрбум ₮) –нар өссөн байна.
 - M1 → ₮-ийн харилцах 99.4 тэрбум ₮-өөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 26.3 тэрбум ₮-өөр өсөв.
 - Бусад хадгаламж → ₮-ийн хадгаламж 307.7 тэрбум ₮-өөр, \$-ийн хадгаламж 66.4 тэрбум ₮-өөр өсч, \$-ийн харилцах 108.9 тэрбум ₮-өөр буурсан байна.

Зураг 3. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар



Зураг 4. Зээл, зээлийн чанар



- Нийт зээл 17.8 их наяд ₮ (Төгрөгийн зээл 15.2 их наяд ₮, Валютын зээл 2.6 их наяд ₮)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас 314 тэрбум ₮ буюу 1.8%-иар өссөн.
- Хэвийн зээл өмнөх сараас 449 тэрбум ₮ буюу 3.1%-иар өссөн.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 159 тэрбум ₮ буюу 16.3%-иар буурсан.
- Чанаргүй зээл өмнөх сараас 24.5 тэрбум ₮ буюу 1.3%-иар өссөн байна.

Зураг 5. Хугацаа хэтэрсэн зээл (салбар бүтэц)



Зураг 6. Чанаргүй зээл (салбарын бүтэц)



- Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 75%-ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.
- Нийт чанаргүй зээлийн 84%-ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Зураг 7. Тайлант сард олгосон ипотекийн зээл




Тайлант сард банкууд **1168** зээлдэгчид **84.3** тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос **50.8%** нь хөтөлбөрийн, **49.2%** нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Зураг 8. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү





Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сараас **0.1** нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс **1.0** нэгж хувиар тус тус буурчээ.

Зураг 9. Нийт шинээр татсан хадгаламж, хүү



- Иргэдээс татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ **11.3%**, хувийн байгууллагаас татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ **9.7%** байна.
- Иргэдэд шинээр олгосон ₮-ийн зээлийн ЖДХ **17.9%**, хувийн байгууллагад олгосон ₮-ийн зээлийн ЖДХ **16.7%** байна.

Зураг 10. Нийт шинээр олгосон зээл, хүү




МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ДУРСГАЛЫН МӨНГӨН ЗООС

Нэр: Монголбанк 95 жил
Зоос №: soh00020
Он: 2019
Металл: Мөнгөн зоос
Жин: 155.5 Грамм
Диаметр: 100 мм
Үнэ: 2,000,000₮
Сорьц: 999
Цуврал: монголбанкны ойн баяр

Нэр: Монголбанк 95 жил
Зоос №: SON00019
Он: 2019
Металл: Мөнгөн зоос
Жин: 31.1 грамм
Диаметр: 38.61 мм
Үнэ: 400,000₮
Сорьц: 999
Цуврал: Монголбанкны
ойн баяр



“МИНИЙ МЭРГЭЖИЛ, МИНИЙ БАХАРХАЛ”

Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойд зориулж Монголбанкнаас санаачлан хэрэгжүүлсэн “Банкны хөгжил-95” аяны хүрээнд Орхон аймгийн Монголбанкны салбараас орон нутгийн иргэдийн дунд зарласан эссе бичлэгийн уралдаанд тэргүүлсэн нийтлэлийг толилуулж байна.



“Бяцхан хүү, өглөө бүр ээж нь түүнийг духан дээр нь үнсэж сэрээгээд нэг ижил хувцсаа өмсөн, үсээ нэг л ижлээр нямбайлан боогоод ажилдаа явахыг хардаг байв. Ээж нь хүүдээ өнгө өнгийн сайхан хувцас авч өгдөг хэрнээ өөрөө үргэлж нэг л хувцсаа өмсдөг болохыг хүү гайхдаг байлаа.

Хүүг орой цэцэрлэгээс аав нь очиж авдаг, гэртээ ирэхэд ээж нь ажлаасаа тарж ирээгүй л байдаг. Аав нь “-Миний хүү ухаантай хүү, ээж нь ажлаасаа ядраад ирэхэд нь ээждээ туслаарай” гэж захидаг байв. Хүү ч аавынхаа үгэнд урамшин ээжийгээ ажлаасаа ирэхэд нь “-Ээжээ би таны нурууг чинь илж өгье, та ядарсан уу?” гэж асуухад, ээж нь жаргалтай инээмсэглээд “-Ээж нь ядраагүй ээ, ийм сайхан сэтгэлтэй, ухаантай хүүтэй ээж хамгийн хүчтэй, шилдэг ээж байдаг юм” гээд бахархсан харц, хайр дүүрэн үнсэлтээр хүүгээ мялаадаг байв.

Цаг хугацаа өнгөрч хүү өсөж томрох тусам ээж нь гэртээ цаг зав бага зарцуулдаг, үргэлж ажилтай байдаг нь хүүд шударга бус санагдаж эхлэв. Харин энэ үед аав нь

хүүг дагуулан ээжийнх нь ажилтай танилцуулахаар гэрэл гэгээгээр дүүрэн, саруулхан шилэн барилгад оров. Хүүгийн ээж банкны ажилтан байв. Түүний ээжтэй уулзахаар өдөрт зуу, зуун аав ээжүүд ирдэг, тэднийг мөн ижил зуу зуун хүүхдүүд нь гэртээ хүлээж байдаг. Ээж нь энэ олон аав ээжүүдийн санхүүг үнэн зөв, түргэн шуурхай хөтлөн, эдгээр аав ээжүүдэд хүүхдүүдийнхээ мөрөөдлийн төлөө зарцуулах мөнгө, гүйлгээг нь шийдвэрлэн өгч, энэ олон аав ээжүүд гэртээ хүлээх хүүхдүүд дээрээ хурдан очиж чаддаг болохыг хүү ойлгож, ээжээрээ маш их бахархав. Мөн ээжийнх нь өдөр бүр өмсдөг хувцас нь ажлынх нь дүрэмт хувцас болохыг мэдэж авав. Ээжтэй нь яг ижилхэн дүрэмт хувцас өмссөн, үсээ нямбайлан самнасан ах эгч нар уулзсан хүн бүрийг инээмсэглэн хүлээн авч, зөвлөгөө өгч, хүндэтгэн ярилцаж байхыг хараад хамтдаа хичээж, хамтдаа ажиллан улам олон аав, ээжүүд, хүүхдүүдэд тусалж, хийсэн ажил бүрийн үр дүн дэлгэрч байдаг болохыг хүү ойлгожээ.

Ингээд хүү ээжтэйгээ яг адилхан мянга, мянган гэр бүлийн аз жаргал, хүсэл мөрөөдлийн

төлөө хичээнгүйлэн ажилладаг, өглөө бүр дүрэмт хувцсаа өмсөөд гарахдаа жаргалтай байдаг банкны ажилтан болно гэж мөрөөддөг болжээ. Хүү мөрөөдлийнхөө төлөө шаргуу суралцан, удам залгасан банкир болж Монгол улсынхаа эдийн засгийн эрх чөлөө, тусгаар тогтнолд үнэтэй хувь нэмрээ оруулан, эх орноо дэлхийн түвшинд хөгжлөөрөө өрсөлдөхүйц улс болоход нь хамтын хүчээр хөтөлсөн олон шилдэг мэргэжилтнүүдийн нэг, шилдэг эдийн засагч болсон юм.”

Намайг Уянга гэдэг. Миний мэргэжил банкны эдийн засагч. Харин энэ бол миний бяцхан хүүгийнхээ ирээдүйн талаарх мөрөөдөл юм. Ямар ч ээж хүн биеэ хувааж төрүүлсэн үрдээ ертөнцийн хамгийн сайн сайхныг хүсдэг. Үүнээс илүүгээр би мэргэжлээрээ хэрхэн бахархдагаа яаж илэрхийлэхээ мэдэхгүй байна.

Та бүхэнд талархан хүндэтгэсэн,

ХХБанкны Эрдэнэт салбарын
захирлын орлогч Б.Уянга

2019.05.09

“МОНГОЛ УЛС СҮҮЛИЙН ХУГАЦААНД ГАРГАСАН ОЛОЛТ АМЖИЛТУУДЫГ НЬ АЛДАГДУУЛАХ ЭРСДЭЛ БҮХИЙ ГАДААД БОЛОН ДОТООД СОРИЛТУУДАЙ ТУЛГАРЧ БАЙНА”

Мүүдиз (Moody's) агентлаг 2019 оны 6 сарын 10

Манай улсын
эдийн засаг,
банк санхүүгийн
салбар дахь
нөхцөл байдлын
талаар Олон
улсын зээлжих
зэрэглэл тогтоогч
Мүүдиз (Moody's),
Фитч (Fitch)
агентлагууд олон
нийтэд хандаж
хэвлэлийн мэдээ
гаргасныг уншигч
танд толилуулж
байна. Хэвлэлийн
тэдгээр мэдээнд
Монгол Улсын
эдийн засгийн
өсөлт, төсвийн
төлөв байдал,
гадаад эрсдэл
болон улс төрийн
нөхцөл байдал,
банкны салбарт
авч хэрэгжүүлсэн
бодлого, үр
дүнгийн талаар
дурьдсан байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд нөлөөлөх эдийн засгийн өсөлт болон төсвийн бат бэх байдал (төсвийн алдагдал, Засгийн газрын өр буурах) сүүлийн жилүүдэд сайжирсан. Гэвч Монгол Улсад гараад буй зарим ахиц дэвшил нь тус улсын эдийн засагт тулгарч буй гадаад болон дотоод сорилтуудын улмаас 2019-2020 онд алдагдаж болзошгүй байна.

Монгол Улсын эдийн засаг нь БНХАУ (A1, тогтвортой)-руу гаргах түүхий эд (голчлон зэс, нүүрс)-ийн экспортоос өндөр хамааралтай байдаг. БНХАУ нүүрсний хэрэглээгээ бууруулж байгаагаас шалтгаалан Монгол Улсын бодит ДНБ-ий өсөлт 2019 болон 2020 онд саарах төлөвтэй байна. Уул уурхайн томоохон төслүүд дэх хөрөнгө оруулалтын тодорхойгүй байдал болон олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурах дарамтууд нь Монгол Улсад нэмэлт сорилтуудыг бий болгож байна.

2020 онд болох УИХ-ын сонгуулийн нөлөөгөөр Монгол Улсын төсвийн алдагдал 2019 болон 2020 онд нэмэгдэх хандлагатай байна. Төсвийн реформ (шинэчлэл) нь ОУВС-гийн хөтөлбөрийн чухал

бүрэлдэхүүн хэсэг юм. Төсвийн реформын хүрээнд авч хэрэгжүүлээд буй арга хэмжээнүүд хэр үр дүнтэй болох нь бодит эдийн засгийн идэвхжил саарах хүлээлттэй байгаа 2019 болон 2020 онд харагдахаар байна.

Экспортын орлого саарч, аж үйлдвэрлэлийн орцын импортын өсөлтөөс шалтгаалан нийт импорт үргэлжлэн өсч улмаар урсгал дансны алдагдал нэмэгдэхээр байна. Үүний зэрэгцээгээр уул уурхайн салбарын гадаад шууд хөрөнгө оруулалт болон хөнгөлөлттэй санхүүжилт (concessional funding)-ийн эх үүсвэрүүд Монгол Улсын гадаад валютын албан нөөцөд дэмжлэг болохоор байна.

Улс төрийн орчин тогтворгүй байгаатай холбоотойгоор хоёр гол хүчин зүйл Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд нөлөөлөхөөр байна. Тодруулбал одоогийн эрх баригчдын ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд бодлогоо хэрэгжүүлэх цаашдын хандлага, мөн уул уурхайн томоохон төслүүдэд хийгдэх гадаадын хөрөнгө оруулалтад хандах хандлага нь голлон нөлөөлөхөөр байна.

“АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ НӨЛӨӨГӨӨР МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ САЛБАР ИЛҮҮ ХҮЧИРХЭГ БОЛНО” ФИТЧ (FITCH) АГЕНТЛААГ 2019 ОНЫ 05 САРЫН 23

Капитал банкны үйл ажиллагааг зогсоож татан буулгасан нь Монгол Улсын банкны системд бүтцийн өөрчлөлт, сайжруулалт хийгдэж буйн илрэл гэж Фитч агентлагийн зүгээс үзэж байна. Мөн түүнчлэн зарим банкуудын хувьд цаашид өөрийн хөрөнгөө дахин нэмэгдүүлэх шаардлага байж болзошгүй ба бүр Активын чанарын үнэлгээ (АЧҮ)-ний үр нөлөөгөөр үйл ажиллагааг нь зогсоож ч магадгүй гэсэн хүлээлт тус агентлагийн зүгээс байгаа хэдий ч эдгээр нь эцэстээ Монгол Улсад ОУВС-гийн зүгээс хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нэг чухал зорилт болох банкны тогтолцоог илүү чадавхжуулахад чиглэх юм.

Монгол Улсын жижиг банкуудын нэг болох Капитал банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалтгүй болсон ба үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь активын чанар эрс муудсантай холбоотой. Уг банкны нийт чанаргүй зээлийн харьцаа 80 хувьд хүрсэн.

Активын чанар нь системийн хэмжээнд сул тал болсон хэвээр байна. Өнгөрсөн жил банкны секторын чанаргүй зээлийн харьцаа 10 хувийг давж өссөн ба зарим банкууд энэ жилийн хувьд ч өмнө олгосон зээл нь төлөгдөхгүй байгаагийн улмаас чанаргүйдэж байгааг тайландаа тусгасаар байна. Үүнээс үүдэн Монголбанк нь АЧҮ-ний дүнд үндэслэн авах арга хэмжээний хүрээнд зарим банкуудын хувьд, ялангуяа системийн нөлөө бүхий бус банкуудын хувьд өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх эсвэл татан буулгах

шаардлагатай дахин тулгарч болзошгүй.

Өнгөрсөн жил Монголбанк зарим банкуудад өөрийн хөрөнгийн дутагдал үүссэнийг тогтоож, 2018 оны 12 дугаар сард багтаан дутагдлыг нөхөх шаардлагыг тавьсан. Худалдаа хөгжлийн банк активын чанар нь эрчимтэй муудсантай холбоотойгоор өөрийн хөрөнгийн харьцаагаа 2018 оны эхний хагаст 15 хувь байсныг жилийн эцэст 20 хувь болгож нэмэгдүүлсэн. Тус банкны чанаргүй зээлийн харьцаа 2019 оны 1 дүгээр улирлын эцэст 14 хувь болж өсөөд байна.

Голомт банкны хувьд өөрийн хөрөнгийн харьцаа 2018 оны эцэст системийн нөлөө бүхий банкны зохистой харьцааны шаардлага болох 14 хувиас яльгүй илүү байсан. 2019 оны эхээс тус банкны чанаргүй зээлийн харьцаа эрчимтэйгээр муудсан ба 2018 оны эцэст 5 хувь байснаас 2019 оны 1 дүгээр улирлын эцэст 10 хувь болж өсөөд байна.

АЧҮ-ний дүнд банкуудын өөрийн хөрөнгө нэмэгдүүлэх хэмжээ нь банкны секторын чанаргүй зээлийн харьцаа 9 хувь байх үед тогтоогдсон. Банкны секторын чанаргүй зээлийн харьцаа 2018 оны эцэст 10 хувь, 2019 оны 4 дүгээр сарын эцэст 11 хувьд хүрсэн нь банкууд дахин өөрийн хөрөнгийн дутагдалд орсон байх маш өндөр магадлалтай. Иймд Фитчийн зүгээс эрх бүхий байгууллага нь ОУВС-гийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хүлээсэн үүргээ биелүүлэх болон банкны секторт итгэх итгэлийг нэмэгдүүлэх хүрээнд өөрийн хөрөнгийн дутагдалд орсон банкуудын өөрийн

хөрөнгийг нэмэгдүүлэх чиглэлд хүчин чармайлт гарган ажиллана гэсэн хүлээлттэй байна.

Капитал банк татан буугдсан нь банкны системд том нөлөө үзүүлэхгүй. Тус банк активын хэмжээгээр банкны системийн зөвхөн 1 хувийг бүрдүүлж байсан. Хадгаламжийн даатгалын корпорациас нөхөн олгогдох Капитал банкны хадгаламжийг Хаан банк (В/тогтвортой/б)-аар дамжуулахаар болсон ба энэ нь Хаан банк тэргүүлэх банкуудын нэг гэдгийг илтгэж байна. Мөн Хаан банкны хадгаламж болон хадгаламж эзэмшигчдийн тоонд богино хугацаанд тодорхой хэмжээний өсөлтийн нөлөөг үзүүлнэ. Хадгаламж нь даатгалаар нөхөн олгогдох ихэнх харилцагч нар Хаан банкны харилцагч болж үлдэнэ гэсэн хүлээлтийг Фитчийн зүгээс тавьж байна.

Капитал банк татан буулгасан нь системийн нөлөө бүхий банкууд болох Хаан банк болон Хас банк (В/тогтвортой/б)-нд үнэлгээ тогтооход нь нөлөөлөх хүчин зүйл болохгүй гэж Фитчийн зүгээс үзэж байна. Мөн дотоодын системийн нөлөө бүхий банкныг дахин хөрөнгөжүүлэх харилцааг зохицуулахаар 2018 онд батлагдсан Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль нь бүхэлдээ ‘туршигдаж’ хэрэгжээгүй боловч төрөөс тогтолцооны шинжтэй эрсдэл тархахаас урьдчилан сэргийлж, тодорхой нөхцөлийг харгалзсаны үндсэн дээр банкны хөрөнгө оруулагчдад эрсдэлийг үүрүүлэхээс илүүтэйгээр дэмжлэг үзүүлэхийг зорьж байгаа гэж тус агентлаг үзэж байна.



1 Зээлийн мэдээлэл гэж юу вэ?

Зээлдүүлэгчийн өмнө хууль, гэрээгээр хүлээсэн зээлдэгчийн зээл, төлбөрийн талаарх мэдээлэл.




2 Зээлийн мэдээллийн сан

Монголбанк болон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн эзэмшиж буй иргэн, төрийн болон хувийн өмчит хуулийн этгээдийн хооронд зээл, төлбөртэй холбогдон үүсэх мөнгөн төлбөрийн мэдээллийг агуулсан мэдээллийн сан.



3 Мэдээлэл нийлүүлэгч хуулийн этгээд

1. Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо;
2. Санхүүгийн түрээсийн компани;
3. Төрийн байгууллага/эд хөрөнгийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон татвар, нийгмийн даатгал, гааль, эрчим хүч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар/ байгууллагыг;
4. Үүрэн холбооны оператор компани болон хуулинд заагдсан бусад хуулийн этгээд



4 Зээлдэгч зээлийн мэдээллийн лавлагааг хаанаас авах вэ?

Харилцагч банкныхаа төв рүү хандаж зээлийн мэдээлэл хариуцсан ажилтнаас авах боломжтой.

5 Зээлдэгчийн зээлийн мэдээллийг хэрхэн ангилдаг вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу төлөгдөж дуусах хугацаа хэтэрсэн эсэхээс хамаарч доорх байдлаар зээлдэгчийн зээл болон өр төлбөрийг ангилдаг. Үүнд:

- Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт 15 хүртэл хоног - Хэвийн
- 90 хүртэл хоног - Анхаарал хандуулах /хугацаа хэтэрсэн/
- 91-180 хоног - Хэвийн бус
- 181-360 хоног - Эргэлзээтэй
- 361-с дээш хоног - Муу



6 Хугацаа хэтрүүлж зээлээ төлсөн, зээлийн сөрөг түүхтэй иргэд аж ахуйн нэгжид зээл олгож болохгүй гэсэн хууль, журам байдаг уу?

Байхгүй. Харин тухайн зээл олгогч байгууллага нь зээлдэгчийн өмнөх болон одоогийн санхүүгийн чадамж, санхүүгийн эрсдэлийг тооцож, зээл олгох эсэх шийдвэрийг гаргана.



7 Зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдсэн сөрөг мэдээллийг хэрхэн өөрчлөх вэ?

- Тухайн иргэн, аж ахуйн нэгж нь зээлийн мэдээллийг өөрчлүүлэх хүсэлтээ зээл олгогч байгууллагынхаа төвд нь гаргаж хууль журмын дагуу шийдвэрлүүлэх боломжтой.
- Монголбанк зээлдүүлэгч байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг харгалзан шалтгаан үндэслэлийг судлах ба өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл зөвхөн төлөгдсөн болон алдаатай нийлүүлэгдсэн зээлийн мэдээлэлд өөрчлөлтийг оруулна.
- Монголбанкнд даалгасан заалт бүхий шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд зээлийн мэдээлэлд өөрчлөлт оруулна.



8 Зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдсэн сөрөг мэдээлэл хэдий хугацаанд хадгалагддаг вэ?

Зээл болон төлбөр нь төлөгдөж дууссан гэсэн мэдээллийг Зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдсэнээс хойш 6 жилийн дараа зээлийн эерэг болон сөрөг бүх мэдээллийг зээлдүүлэгч байгууллага ашиглах боломжгүй болно. Өөрөөр хэлбэл тухайн мэдээлэл нь Зээлийн мэдээллийн сангаас харагдахгүй гэж ойлгож болно.



С.ГАНБАЯР: ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖҮҮД ЗЭЭЛЭЭ ХУГАЦААНДАА ТӨЛӨХ ЭРМЭЗЭЛТЭЙ БОЛЖ БАЙНА

Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс хамгийн сонирхсон асуултуудын хүрээнд Зээлийн мэдээллийн сангийн дарга С.Ганбаяртай ярилцлаа.

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН
САНГИЙН ТУХАЙ БИД
ӨМНӨХ ДУГААРТАА ТАНТАЙ
ЯРИЛЦАЖ БАЙСАН ШҮҮ
ДЭЭ. ЭНЭ УДАА ДАХИН ЭНЭ
СЭДВЭЭРЭЭ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН
ЯРИЛЦЬЯ. ЗЭЭЛИЙН
МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ТУСДАА БИЕ
ДААСАН АЛБА ХАРИУЦАХ
БОЛЖЭЭ. ИНГЭСНЭЭР ҮЙЛ
АЖИЛЛАГААГ НЬ УЛАМ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД
АНХААРЧ БАЙНА УУ?**

Өмнө нь олон жилийн турш ЗМС-ийн үйл ажиллагааг Монголбанкны Хяналт шалгалтын газарт нэг л ажилтан хариуцан ажиллаж ирсэн. Харин олон улсын байгууллага болох Олон улсын валютын сан, Олон улсын санхүүгийн корпорацийн зөвлөмж болон банк санхүүгийн тогтвортой байдлыг хангахад тус сангийн үр нөлөө, хүртээмжийг улам нэмэгдүүлэх, олон улсын шаардлага, станадартад нийцүүлэх шаардлагатай гэж Монголбанкны удирдлагаас үзсэн

тул 4 хүний бүрэлдэхүүнтэй бие даасан зээлийн мэдээллийн нэгжийг 2019.04.01-ний өдрөөс эхлэн байгуулсан. Өнөөдрийн байдлаар Монголбанк нь 670 гаруй төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан мэдээлэл солилцох үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид эдгээр байгууллагын тоо ойролцоогоор 2 дахин нэмэгдэхээр байна. Иймээс бид, ЗМА шинээр байгуулагдсантай холбогдуулан үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг хурдан шуурхай болгох зорилгоор тэргүүн ээлжинд дүрэм журмаа шинэчлэн боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. Мөн програм хангамж, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, хөгжүүлэх, ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх ажлыг олон улсын байгууллагатай хамтран аль болох богино хугацаанд хийж гүйцэтгэхээр тохироод байна.

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН
САНГИЙН АЛБА ШУУД
ИРГЭДТЭЙ ХОЛБОГДОЖ
МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ
БОЛОМЖТОЙ БОЛСОН УУ?**

Бид өмнө нь ч одоо ч иргэд ахуйн нэгжтэй холбогдож мэдээлэл болон зөвлөмжийг өгч байгаа ба цаашдаа ч ингэж ажиллах болно. Би нэг жишээ тоо баримт хэлмээр байна. Манай ЗМА-нд өдөрт дунджаар, цахим шуудангаар 70-120, утсаар 40-60 иргэн ханддаг, биечлэн 15-20 иргэн ирж уулздаг ба бид холбогдох мэдээлэл зөвлөгөө өгөхөөс гадна тэднээс ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч аль болох богино хугацаанд шийдвэрлэж байна.

Иргэдээс ирдэг хамгийн түгээмэл асуултуудад энд мөн хариулт өгөхийг хүсч байна.

Иргэд зээлийн түүхээ сайн мэддэггүй, хаанаас ямар зээл авсанаа санадаггүйгээс зээлийн мэдээллийн лавлагаагаа гаргуулж авах, мөн зээлийн түүхэнд байгаа сөрөг буюу чанаргүй зээл,

төлбөрийн мэдээллийг хэрхэн засуулах асуудлаар маш олон иргэд бидэнд ханддаг.

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН
САНД ХАДГАЛАГДСАН
ХУГАЦААГ ЦУЦЛУУЛАХ
ХҮСЭЛТЭЙ ИРГЭД НЭЛЭЭД
ХАНДДАГ БАЙХ. ТИЙМ
БОЛОМЖ БИЙ ЮУ?**

Зээлийн мэдээллийн тухай хуулийн дагуу иргэн, аж хуйн нэгжийн зээлийн мэдээллийг 10 жил хадгалах ёстой ба харин зээл олгогч байгууллага нь иргэн, аж хуйн нэгжийн сүүлийн 6 жилийн зээлийн мэдээллийг зээл олгох шийдвэр болон судалгаандаа ашигладаг. Өөрөөр хэлбэл тухайн зээл нь бүрэн төлөгдөж дууссанаас хойш 6 жилийн дараа тухайн зээлийн мэдээлэл нь зээл олгогч байгууллагад харагдахгүй болно гэсэн үг.

**ӨДӨРТ ЕР НЬ ХИЧНЭЭН
МЭДЭЭЛЭЛ БҮРТГЭГДДЭГИЙГ
СОНИРХОЖ БОЛОХ УУ. АЛЬ
ТӨРЛИЙН МЭДЭЭЛЭЛ НЬ
ИЛҮҮ ДАВАМГАЙЛДАГ ВЭ?**

Би дээр хэлсэн, Монголбанк 670 гаруй байгууллагатай хамтран мэдээлэл солилцох үйл ажиллагаа явуулдаг. Манай ЗМС-нд эдгээр байгууллагаас нэг өдөрт маш олон мэдээлэл орж ирдэг гэсэн үг. Надад нарийн тоог хэлэх боломж байхгүй байна.

**ЕР НЬ ЭНДЭЭС ДҮГНЭХЭД
ЯМАР НАСНЫХАН МӨН
ИРГЭН БАЙГУУЛЛАГААС
АЛЬ НЬ ИЛҮҮ САНХҮҮГИЙН
САХИЛГА ХАРИУЦЛАГАТАЙ
ХАРАГДДАГ ВЭ?**

Ер нь сүүлийн жилүүдэд иргэн, аж хуйн нэгжүүд маань авсан зээлээ аль болох хугацаандаа төлөх

эрмээлтэй, соёлтой болж байна. Энэ дээр нэмээд хэлэхэд иргэн, аж хуйн нэгжүүд маань авсан зээлээ хугацаандаа төлдөг ухамсар соёлоо төлөвшүүлчихвэл санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, банк санхүүгийн салбарын тогтвортой байдал хангагдана. Цаашлаад улс эх орны маань эдийн засаг сайжирч хөгжихөд маш их эерэг нөлөөтэй гэдгийг хэлж зөвлөмөөр байна

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН
ГЭДЭГ БОЛ ИРГЭДЭД ДАРАМТ
ҮҮСГЭЖ БАЙГАА ХҮНД
СУРТАЛ ҮҮНИЙГЭЭ БОЛИУЛ
ГЭЖ ХАНДАХ БУХИМДСАН
ИРГЭД БАЙДАГ Л ДАА.
ТЭДНИЙ ЗҮГЭЭС ЯАГААД
ЗААВАЛ БАЙХ ЁСТОЙ ГЭЖ
ГЭДЭГ АСУУЛТАД ТА ЯМАР
ХАРИУЛТ ӨГӨХ ВЭ?**

Зээлийн мэдээллийн санг иргэн, аж хуйн нэгжийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх гол хөшүүрэг, хэрэгсэл болгон дэлхий нийтээрээ 19 зууны сүүл үеэс эхлэн хөгжүүлж байна. Банк, санхүүгийн салбарын гол эрсдэл нь гэрээний дагуу хугацаандаа төлөгдөөгүй зээл, авлага, төлбөр бөгөөд үүнээс шалтгаалан банк, санхүүгийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдаж, улмаар системийн хэмжээнд санхүүгийн зуучлалын үйл ажиллагаанд доголдол үүсэх эрсдэл бий болдог. Иймд банк, санхүүгийн байгууллага санхүүгийн үйлчилгээ үзүүлэх эсэх шийдвэр гаргалтад Зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашигласнаар эрсдэл учрахаас урьдчилан сэргийлж, өөрийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах бололцоог олгодог. Нөгөө талаар санхүүгийн сахилга бат сайтай иргэн, аж хуйн нэгж

илүү бага хүүтэй, их хэмжээ болон урт хугацаатай зээлийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж өгдөг сайн талтай.

**НИЙГМИЙН ДААТГАЛ
ТӨЛӨӨГҮЙ ААН-ИЙН
МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГЭДЭГ
БОЛНО ГЭДЭГ ДЭЭР БАС
Л ЗӨРҮҮТЭЙ БАЙР СУУРЬ
НИЙГЭМД БАЙСАН?**

Зээлийн мэдээллийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын салбар нь харилцагч аж хуйн нэгж, байгууллагынхаа нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөртэй холбоотой мэдээллийг манай ЗМС-нд нийлүүлэх үүрэгтэй. Энэ дагуу НДЕГ бидэнтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, бэлтгэл ажлаа хангаад байна. НДЕГ-т өртэй, өөрөөр хэлбэл ажилчдынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй зөвхөн аж хуйн нэгжийн мэдээлэл нийлүүлэгдэх бөгөөд иргэдэд ямар нэг асуудал үүсгэхгүй болно.

**ДАХИН ТОДРУУЛАХАД,
ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН
САНГИЙН НИЙГЭМД
ҮЗҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДЛЫГ
ТАЙЛБАРЛАЖ ӨГНӨ ҮҮ.**

Зээлийн мэдээллийн сан нийгэмд үзүүлэх ач холбогдлын тухай өмнөхөө дахиад давтан хэлэхэд иргэд аж хуйн нэгжүүд маань авсан зээлээ аль болох гэрээний дагуу хугацаандаа төлөх ухамсар, соёл төлөвшин тогтчихвол санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, зээлийн хүү буурах, чанаргүй зээлийн хэмжээ буурснаар банк санхүүгийн салбарын тогтвортой байдал хангагдах ач холбогдолтой.

БАЯРЛАЛАА.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 26/VI ӨДРИЙН БАЙДЛААР)**



ОРЧИН ҮЕИЙН БАНКНЫ ХӨГЖИЛД ГАРСАН ЗАРИМ ЧУХАЛ ОЙЛГОЛТ

Хүний нийгмийн хөгжилтэй зэрэгцэж үүсч хөгжсөн нэг чухал зүйл бол санхүүгийн үйлчилгээ, тэр дундаа банкны үйлчилгээ юм. Хүмүүс, худалдаачид эд хөрөнгөө найдвартай хадгалах шаардлага тулгарч байсны шийдэл нь гар урчууд, алт мөнгөний дархчууд байсан. Тийм ч учраас 16 зуунд Венецэд үнэт эдлэл авдаг вандан ширээг "Banco" гэж нэрлэдэг байснаас банк хэмээх нэршил үүсчээ.

Өдгөө банкны үйл ажиллагаагаа ихээхэн нарийн, түвэгтэй болсон ч үндсэн зарчим нь хэвээр хадгалагдсаар байна. Иргэдийн мөнгийг хадгалах үйлчилгээг нэг талд үзүүлж, нөгөө талд тэр эх үүсвэрээр зээл олгох нь арилжааны банкны зарчим. Мэдээж үүн дээр төлбөр тооцооны үүрэг нэмэгдэж ирснээр хүн төрөлхтөний цаг хугацаа болон мөнгийг хэмнэж, илүү тухтай амьдрах боломжийг бий болгосон. Гэхдээ банкны үйл ажиллагаанд нэвтэрсэн хамгийн чухал зүйл бол санхүүгийн зохистой харьцааг хангах явдал юм.

ЗОХИСТОЙ ХАРЬЦААГ ХАНГУУЛАХ НЬ

Банк нь үүсгэн байгуулагч, эздийн хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаагаа эхлүүлдэг ба үүн дээр бусдаас санхүүгийн эх үүсвэр татсанаар ашиг олдог бизнес. Үүнийг санхүүгийн хэллэгээр хөшүүргэ гэдэг. Тухайлбал, Монгол Улсад эздийн хөрөнгийн зохистой харьцааг 12 хувь ба түүнээс дээш байхаар зохицуулж өгсөн. Иймэрхүү 12 хувийн хөрөнгө дээр хадгаламж зэрэг бусдаас татсан 88 хувийн мөнгөөр ашиг олохыг хөшүүрэг гэнэ (дараах зургийг үзнэ үү).

Амьдралд эрсдэл гэдэг ойлголт тогтмол оршсоор байдаг бөгөөд энэ нь санхүүгийн харилцаанд ч анхаарвал зохих хамгийн чухал зүйл юм. Банкны бизнес эрсдэлийг зохистой түвшинд байлгаж, удирдсанаараа амжилттай ажилладаг. Харин эрсдэлийг удирдах гэдэг ойлголт нь он цагийн эрхээр өөрчлөгдөн хөгжсөөр байна. Эрт цагт зохистой харьцааг хангуулах тогтолцоо байхгүйгээс олон банк дампуурлаа зарласан түүхтэй бол өдгөө энэ тоо улам багассаар байна.

Ялангуяа 2008 оны хямрал тохиолдсоноос хойш банкны хяналт шалгалт, зохистой харьцааг хангуулах үйл ажиллагаа шинэ түвшинд гаргасан. Тэр дундаа банкны хяналт шалгалтын тогтолцоо асуудал үүссэний дараа арга хэмжээ авах биш асуудал үүсэхээс өмнө урдчилан сэргийлэх чиглэлд хөгжиж байна. Үүнийг эрсдэлд суурилсан хяналт шалгалт гэдэг. Монголбанкны мэдээлэл товхимлын өмнөх дугааруудад банкны хяналт шалгалтын Базелийн хорооны талаар тайлбарласан. Тус хороос олон улсын банкуудыг энэ чиглэлд хөгжихөд түлхэц үзүүлж байна.



МОРАЛ ХАЗАРД

Дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралын дараа “дампуурахад хэт том” банк гэдэг хэллэг бий болсон. Угаас системийн хэмжээний томоохон банкийг улс дампууруулахыг зөвшөөрөхгүй. Хэрэв банк, санхүүгийн тогтвортой байдал алдагдах аваас санхүүгийн секторын нэг чухал эргэлт зогсож, иргэдийн итгэл сулрах, цаашлаад эдийн засгийн бүх салбарт сөргөөр нөлөөлөх учраас томоохон банкуудын тогтвортой байдлыг хангахын тулд төв банк болон засгийн газраас оролцох жишиг тогтжээ. 2008 оны санхүүгийн хямрал нь АНУ-ын Леман Бродерс, Вашингтон Мутуал зэрэг хэмжээгээрээ тэргүүлэх банкууд дампуурснаар эхэлж, даамжирсан. Тухайн үед тэдгээр банкуудыг засгийн газар нь зөнгөөр нь дампуурахыг зөвшөөрсөн боловч газар авч бусад банкуудад, эдийн засагт муу нөлөө үзүүлж эхэлсэн учир өөр банк хүндрэх тоолонд засгийн газраас “бейл-аут” буюу хөрөнгө оруулах тусгай арга хэмжээг авч эхэлсэн. Өнөөдөр дампуурахад хэтэрхий том гэдэг ойлголт банкны салбараас хальж эдийн засагт нөлөө бүхий компаниудыг хамруулдаг болсон ба тусдаа онолын хэмжээнд судлагддаг болсон.

Засгийн газраас аврах арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа үед нэг маргаантай асуудал үүсдэг нь “морал хазард” юм. Хэрэв чи бүтэлгүйтэж, мөнгөө алдсан ч тэр мөнгийг өөр хэн нэгэн нөхөж олгох нь тодорхой бол бүтэлгүйтлийг тоохоо больж байдаг л нэг зүйл мэт бодох болно. Цаашлаад хэрэв чи хүний мөнгөөр бизнес хийгээд алдагдал хүлээх үед засгийн газар дэмжлэг үзүүлэх нь тодорхой бол айх зүйлгүйгээр ашгаа нэмэгдүүлэхийн тулд улам их эрсдэлтэй үйл

ажиллагаанд оролцох сэдлийг төрүүлнэ. Үүнийг морал хазард гэдэг ба сонирхлын эсвэл ёс зүйн гажуудал гэж орчуулах тал бий. Морал хазардын амьдралд ойр өөр нэг жишээ бол даатгал. Жолоочийн хариуцлагын эсвэл эд хөрөнгийн бусад даатгал авсны дараа даатгуулагч нь эд зүйлстэй гамгүй хандаж, осол гарч, гэмтсэн ч гэлээ даатгалын компаниас мөнгөө авчих юм чинь гэсэн байдлаар хандаж эхлэх нь морал хазард юм.

Тэгэхлээр дампуурахад хэтэрхий том банкийг хэрхэн зохицуулах вэ гэсэн асуудал хөндөгдөж эхлээд байгаа. Зарим томоохон эдийн засагчид хэт том банкны төвлөрлийг хувааж, эрсдэлийг бууруулахыг санал болгодог. Үүнийг мөн диверсификаци гэх ба үйл ажиллагааны чиглэл тус бүрээр нь тусдаа компани байгуулах эсвэл зарах үйл ажиллагаа юм. Зарим банк, компаниуд үндсэн үйл ажиллагаагаа авч үлдээд бусад бизнесийн бүтцээ зардаг. Пол Кругман зэрэг нөлөө бүхий эдийн засагчид харин үүнийг төдий л дэмждэггүй, зах зээлд тодорхой хэмжээний зохицуулалт байх нь зөв ч хүчээр аль нэг компанийг хуваах нь зохисгүй гэж үздэг. Тэд зах зээлийн зарчим нь өөрөө том тоглогч, жижиг тоглогчдыг бий болгодог аж.

1992 ОНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан шинэ

Үндсэн хуулиар төрийн “сүлд”, “далбаа”-г шинэчлэн, улсын нэрийг өөрчилжээ.

Иймд мөнгөн тэмдэгийг шинэчлэх шаардлага зүй ёсоор урган гарчээ. 1993 онд 1, 5, 10, 20, 50, 100, 500, 1000-н төгрөг, 1994 онд 5000-н төгрөг, 1995 онд 10000-н төгрөг, 2006 онд 20000-н төгрөгийн дэвсгэртийн тус тус хэвлэж гүйлгээнд гаргажээ. 5, 10, 20, 50, 100-н төгрөгийн дэвсгэрт, 500, 1000-н төгрөг, 5000, 10000-н төгрөгийн дэвсгэрт адил зураг чимэглэл, бичвэртэй бөгөөд нэрлэсэн үнэ, өнгөөрөө ялгагдана. Шинэ мөнгөн тэмдэгт нь усан хээ, ялтсан утас, бичил бичвэр, солигддог зураг зэрэг олон төрлийн нууцлалтай. Серийн дугаар нь хоёр үсэг, долоон оронтой тоотой.





ЖЭФФ ГОТТЛИЙБ: ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ ГУРВАН ТЭРБУМ ДОЛЛАР ДАВСАН САЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ГАРЛАА

ОУВС-ийн ажлын хэсэг өнгөрсөн сарын 19-28-нд Монгол Улсад ажиллав. Тус ажлын хэсгийн ахлагч Жэфф Готтлийб айлчлалын үр дүнгийн талаар мэдээлэл өгч, сэтгүүлчдийн асуултад хариулав.

Олон улсын валютын сангийн Улаанбаатар дахь суурин төлөөлөгчийн газраас мэдээлэл хийлээ. ОУВС-гийн Ажлын хэсгийн дүрмийн IV заалтын 2019 оны зөвлөлдөх яриа хэлэлцээг хийж дуусгасан байна. Монголд ажилласан Ажлын хэсгийн ахлагч Жэфф Готтлийб Валютын сангийн Монгол Улсад хэрэгжүүлж байгаа хөтөлбөр болон Ажлын хэсгийн тайлангийн талаар дараах мэдээллийг өгсөн юм.

Тэрээр Монголын эдийн засагт 2017 оны эхэн үетэй харьцуулахад нааштай өөрчлөлтүүд гарч, эдийн засаг харьцангуй өндөр өсөлттэй

байна. Эдийн засаг сайжрахад гадаад орчин болон гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь нөлөөлөв. Уул уурхайн гол түүхий эд болох нүүрсний экспортын хэмжээ болон үнэ өссөн, Оюутолгой хөрөнгө оруулалт эрчимжсэн нь Монголын эдийн засагт эерэгээр нөлөөлжээ. Дээр нь Засгийн газрын зүгээс хэрэгжүүлсэн зохистой, тууштай бодлого чухал байсан. Төсвийн алдагдал багасч, төсвийн тэнцэл 18 хувиар сайжирсан, өрийн хэмжээ багасч, ДБН-ий 75 хувьтай тэнцээд байна. Мөн гадаад валютын албан нөөц гурван тэрбум ам.доллар давсан зэрэг сайн үзүүлэлтүүд гарлаа.

Цаашид эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалж, оновчтой, хүртээмжтэй болгохын тулд эрх баригчид бодлогоо тууштай хэрэгжүүлэх нь зүйтэй. Өсөлт хүртээмжтэй биш байгаагаас өрхийн

өр болон ядуурлын түвшин нэмэгдэж байна. Тиймээс Монгол Улс эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгоход анхаарч ажиллахыг зөвлөлөө. Мөн Валютын сангаас Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, бодлогыг өргөжүүлж, гурван асуудлыг анхааруулж байна.

Төсвийн зохистой бодлогоо үргэлжлүүлэх хэрэгтэй. Зардлаа өсгөхдөө эдийн засгаа дэмжиж ядуурал, өрхийн дарамтыг бууруулахад чиглүүлэх.

Банкуудын зээлийн өсөлтийг хязгаарлах. Ханш болон инфляцийн өсөлтөд анхаарах.

Банкны хяналт шалгалтыг чангатгаж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах хэрэгтэй байгааг санууллаа.

“
ЭЦЭСТ НЬ
ВАЛЮТЫН
ХАНШ ОЛОН
ХҮЧИН ЗҮЙЛЭЭС
ХАМААРДАГ
БӨГӨӨД ҮҮН
ДЭЭР ЯМАР
НЭГ БАЙДЛААР
БАЙНГА
МОНГОЛБАНКЫГ
ШҮҮМЖЛЭХ НЬ
БУРУУ ЮМ.”

ОУВС-гийн хөтөлбөрөөс орж ирэх ёстой санхүүжилт хугацаанаасаа хоцорсон байгаа. Гэтэл хөтөлбөр дуусах хугацаа дөхөж байна. Тэгэхээр орж ирэх ёстой санхүүжилтийг хугацаанд нь багтааж оруулах уу?

Төв банкны шалгалтын дагуу банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн байвал Захирлуудын зөвлөлд асуудлыг оруулаад санхүүжилтийг олгоно. Энэ үйл явц маань хүлээгдэж байгаа учраас үнэлгээ хойшлогдсон. Хоёр үнэлгээг хамтатгаад хийж болно. Товчхондоо, ОУВС-гаас орох бүх санхүүжилтийг олгоно. Гэхдээ хөтөлбөрийн анх тохирсон хэмжээг гүйцээж, хугацаандаа бүх санхүүжилтийг олгож чадахгүй болов уу гэж бодож байгаа. 2020 оны тавдугаар сар гэхэд олгогдох ёстой санхүүжилтыг бүрэн олгож дуусаагүй байвал Монгол Улсад хоёр сонголт үлдэнэ. Нэг нь хөтөлбөрийн хугацааг уртасгах. Нөгөөх нь дахин шинээр хөтөлбөр тохирох.

Төв банкны үнэт цаас сүүлийн үед нэмэгдээд байгаа. Энэ нь эдийн засагт эрсдэл дагуулах тухай асуудал бий л дээ. Үүнийг хэрхэн харж байгаа вэ?

Төв банкны үнэт цаас бол эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалдаг маш чухал бодлогын хэрэгсэл. Төв банк гадаад валютын нөөцөө нэмэгдүүлж байгаа тохиолдолд үнэт цаас нь дагаад нэмэгдэхээс өөр аргагүй байдаг. Эдийн засгийнхаа онолоор шүү дээ. Яагаад гэвэл нэгдүгээрт, эдийн засагт инфляцийн дарамт үүсэхээс сэргийлэх, хоёрдугаарт, валютын ханшийн уналтаас сэргийлэх

зорилготой байдаг. Монгол Улсын тухайд өнгөрсөн гурван жилд Төв банк гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэх бодлого барьж байгаа тул түүнийгээ дагаад Төв банкны үнэт цаас нэмэгдэж байгаа юм. Энэ бол зах зээлийнхээ дагуу л явж байгаа хэрэг. Гэхдээ нөгөө талаасаа Төв банкны үнэт цаасны хэмжээ нэмэгдэх хэрээр тус банкны баланс дээр тодорхой хэмжээний зардал нэмэгдэж байдаг.

Банкуудын зээлд өр орлогын хязгаар тавьж байгаа. Үүнээс үүдээд ББСБ-аас өндөр хүүтэй зээл олголт ихсэх эрсдэл байгаа. Энэ зээлийн хязгаар зөв үү?

-Төв банк иргэдийн өр орлогын харьцаан дээр хязгаарлалт тавьсан нь маш зүйтэй бодлогын арга хэмжээ юм. Энэ нь нэгдүгээрт, зээлийн өсөлтийг хязгаарласан. Цаашлаад төлбөрийн тэнцэл, инфляц, валютын ханшин дээр бий болж байсан дарамтыг буулгасан. Хоёрдугаарт, санхүүгийн харилцагчийн эрх ашгийг хамгаалах буюу өрхийн орлогыг хамгаалах бодлого юм. Иргэд өөрсдийнх нь орлогын ихэнх хувь нь өрийн үйлчилгээнд яваад байхад анзаардаггүй байсан бол Төв банкны энэ бодлого хэрэгжсэнээр өөрчлөгдөх боломж бүрдэнэ. Хамгийн сүүлд зээлийн харьцааг 60 хувь болгосон шүү дээ. Үүнийг олон улсын туршлагаар харахад өндөр байгаа. Тэгэхээр цаашид ч үүнийг бууруулах ёстой. Нөгөө талаас арилжааны банкуудын зээлд хязгаарлалт тавьснаар иргэд ББСБ-уудыг зорьж байгаа. Энэ салбарын зохицуулалт банкуудтай харьцуулбал сул байж магадгүй. Тэгэхээр энэ салбарын хяналтыг ч сайжруулах хэрэгтэй.

-Монгол Улс эдийн засгийн

**хувьд ямар эрсдэлтэй байна вэ.
Энэ онд хар жагсаалтад орох
эрсдэл бас байгаа?**

-Банкны салбарын шинэчлэлийг эдийн засаг өсөлттэй үед хийх нь хамгийн зөв байдаг. Одоогийн энэ Монгол Улсын эдийн засгийн өсөлт бол маш өндөр өсөлт. Банкны салбарын шинэчлэлийг эдийн засаг муу байхад хийвэл эргээд эрсдэлд оруулдаг. Одоо бол маш тохиромжтой цаг үе.

Саарал жагсаалтын асуудал бол ОУВС-тай шууд хамааралгүй бөгөөд мөнгө угаах терроризмтэй тэмцэх чиглэлээр ажилладаг FATF буюу бүсийн APG байгууллагуудтай холбоотой. ОУВС-ын зүгээс Монгол Улсын мөнгө угаах терроризмтэй тэмцэх хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр техникийн туслалцаа үзүүлсэн. Гэхдээ асуудлын гол нь хэрэгжилтийн хоцрогдол байгаа тул үүнийг сайжруулах хэрэгтэй. Үүн дээр эрх баригчид болон олон нийтийн зүгээс анхаарал хандуулж байгаа нь баярлууштай юм.

Зээлийн хүүд хязгаар тогтоох тухай хэлэлцүүлгүүд өрнөж, хуулийн төсөл боловсруулагдсан байна. ОУВС-гаас үүнийг хэрхэн үзэж байна вэ?

-Зээлийн хүүд дээд хязгаар тогтоох тухай хуульд ямар тогтолцоо, зүйл заалт оруулж байна вэ гэдгийг харах хэрэгтэй. Ер нь мөнгө хүүлэлтийн эсрэг хууль тогтоомж байх нь нийтлэг туршлага. Хүмүүс 50, 60 хувийн хүүтэй зээл авахгүй байхын эсрэг

хууль байх нь бол зөв. Харин нөгөө талдаа зээлийн хүүгийн хязгаарыг 15, 20 гэх мэт бага хэмжээнд тогтоох юм бол эдийн засагт том гажуудал бий болгоно. Арилжааны банкуудын тухайд зээлийн хүүгээрээ дамжуулж, өөрсдийн үйл ажиллагааны зардлыг нөхөн санхүүжүүлж байдаг. Тэр зардлаа санхүүжүүлэх боломж нь зээлийн хүүгийн дээд хязгаараар хумигдвал, олгож байгаа зээлийнхээ хэмжээнд хязгаарлалт хийнэ.

Монгол Улс банкнаас илүү ломбард, ББСБ-ын зээлийн хүүд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Учир нь тэднээс үйлчилгээ авдаг айл өрх олон бий. Тэдгээр иргэдийн эрх ашгийг хамгаалах нь илүү чухал зорилт гэж харж байна. Банкны системийн тогтолцоонд сөргөөр нөлөөлөх хэмжээнд зээлийн хүүд хязгаар тогтоовол валютын сангийн хөтөлбөр хэрэгжихэд хүртэл сөрөг нөлөөтэй.

Валютын ханш Монгол Улсад сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа. Үүнд Төв банкныг буруутгах хандлага бий. Төгрөгийн тогтвортой байдлыг Төв банк гацаараа хангаад явах хэрэгтэй юу?

-Төгрөгийн ханшийн тухайд хэд хэдэн зүйл хэлмээр байна. Валютын ханш унана гэдэг бол эдийн засгийн бодлого амжилтгүй байна гэсэн үг биш. Энэ бол эдийн засгийг эрүүл чийрэг авч явахад зайлшгүй тулгардаг зүйл. Ханшийн уналт явагдаж байвал, тухайн системд

алдаа гарсан байна гэдэг дүгнэлтийг автоматаар хийж болохгүй. Гэхдээ Монголынх шиг эдийн засагт ханшийн уналт их хэмжээгээр явагдвал хувийн компанийн санхүү болон инфляцид сөргөөр нөлөөлнө. Өрсөлдөх чадвартай ханшийн тогтвортой байдлыг дунд хугацаанд бий болгохын тулд дараах гурван зүйлийг анхаарах хэрэгтэй. Нэгдүгээрт, мөнгөний болоод төсвийн бодлого хангалттай хэмжээнд хатуу байх. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Монгол Улсын төсвийн бодлого хангалттай хатуу байсан. Харин мөнгөний бодлого харьцангуй зөөлөн байлаа. Энэ нь зээлийн өсөлтөөр харагдсан. Тэгэхээр цаашид төсвийн тэнцэл ашигтай байж, зээлийн өсөлтийг бууруулах хэрэгтэй. Сүүлийн үед Монгол Улсад автомашины импорт нэмэгдсэн. Энэ нь төлбөрийн тэнцлийг алдагдалд оруулж байна. Хоёрдугаарт, хөрөнгө оруулалтын орчин. Монгол Улс урт хугацаатай гадаадын хөрөнгө оруулалтыг татахад анхаарах хэрэгтэй. Ингэснээр төгрөгийн ханш тогтвортой байхаас гадна ажлын байр нэмэгдэнэ. Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын 50 хувь зөвхөн ганц компаниас хамаарч байгаа. Монгол Улс үүнээс ч илүү нөөц бололцоо байгаа. Тэгээд эцэст нь валютын ханш олон хүчин зүйлээс хамаардаг бөгөөд үүн дээр ямар нэг байдлаар байнга Монголбанкныг шүүмжлэх нь буруу юм.



“ЗЭЭЛИЙН ХҮҮНИЙ ДЭЭД ХЯЗГААР ТОГТООХ БОЛОН МӨНГӨ ХҮҮЛЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН МОНГОЛБАНКНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Нэг. Манай оронд зээлийн хүүг бууруулах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мөнгө хүүлэлтийг зогсоох, иргэд хоорондын богино хугацаатай, өндөр хүүтэй зээлийн харилцааг зохицуулах бодит шаардлага байна.

Хоёр. Гэхдээ банкны салбарт захиргаадалтын аргаар хүүг хязгаарлах оролдлого нь зах зээл, эдийн засагт нэмэлт гажуудлыг бий болгох эрсдэлтэй тул тогтвортой хэрэгжих боломжгүй юм. Ялангуяа макро эдийн засгийн болон санхүүгийн зах зээлийн тогтвортой орчин бүрэн бүрэлдээгүй өнөө үед зээлийн хүүг захиргаадалтын аргаар бууруулах оролдлого нь санхүүгийн зуучлалыг зогсоож, хөрөнгийн зугталтыг бий болгож, санхүүгийн хүртээмжийг хумьж, эдийн засгийг хүндрэл рүү хөтлөх эрсдэл өндөр байна.

Гурав. Банкны салбарын зээлийн хүү нь эх үүсвэрийн хүү, зээлдэгчийн эрсдэлийн түвшинтэй уялдан тогтдог тогтолцоонд захиргаадалтын аргаар шууд нөлөөлөх

нь жижиг, дунд бизнес эрхлэгч, бага орлоготой иргэд болон орон нутгийн зээлдэгчдэд хүрэх зээлийн үйлчилгээг хумьж, хүртээмжийг бууруулна. Энэ нь эргээд албан бус зээлийн үйлчилгээ хөгжих нөхцөлийг бий болгож, санхүүгийн байгууллагын шимтгэл өсөх зэрэг сөрөг үр дагавартай билээ. Бусад орны жишээ, сургамжаас харахад, зээлийн хүүний дээд хязгаарыг хуулиар тогтоох анхны санаа нь зээлийн хүү хэт өндөр, зээлийн үйл ажиллагаанд мөнгө хүүлэлтийн хэв шинж байна гэсэн олон нийтийн хүсэл, сонирхолд нийцүүлж буюу зээлийн төлбөрийн дарамтыг бууруулах, санхүүгийн хүртээмжийг сайжруулах гэсэн зорилготой байсан боловч бодит байдал дээр сөрөг нөлөө үзүүлдэг жишээ байна. Тухайлбал:

- Баруун Африкийн орнууд (Бенин, Буркина-Фасо, Мали, Нигер, Синегал, Того, Кот-Дивуар, Гвиней-Бисау) 2014 онд зээлийн хүүний дээд хязгаар тогтоосон хэдий ч үүний нөлөөгөөр алслагдсан бүс нутаг үйл ажиллагаа эрхлэх

санхүүгийн байгууллагын тоо эрс цөөрч, ядуу иргэд болон алслагдсан бүс нутгийн иргэд зээл авч чадахгүйд хүрчээ.

- ХБНГУ, Франц улсад зээлийн хүүний дээд хязгаар тогтоосон нь бага орлоготой иргэд болон өрхүүдэд зориулсан зээлийн бүтээгдэхүүний төрлийг бууруулж, бага орлоготой, харьцангуй өндөр эрсдэлтэй зээлдэгчид зээлийн үйлчилгээнээс хасагдахад хүргэжээ.
- Латин Америкийн орнууд (Эквадор, Перу, Мексик, Бүгд Найрамдах Доминикан улс) зээлийн хүүний дээд хязгаар тогтоосон нь бичил санхүүгийн байгууллагын зээл олголтыг бууруулж, хөдөө орон нутгаас санхүүгийн байгууллага дүрвэж, хүүний бус шимтгэл, хураамжийг нэмэгдүүлсэн зэрэг сөрөг нөлөөний улмаас тус улс орны жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ), бизнес эрхлэгчид илүү хохирол амссан байна.



- Кени улс 2016 онд зээлийн хүүний дээд хязгаар, хадгаламжийн хүүний доод түвшинг хуулиар тогтоожээ. Үр дагаварт нь банкууд эрсдэлээ бууруулах зорилгоор том аж ахуйн нэгж, байгууллагад зээлийн үйлчилгээг түлхүү үзүүлж, ЖДҮ эрхлэгч болон хэрэглээний зээл хүсэгчдэд өндөр шаардлага тавьж, тэдгээрт олгох зээлийн хэмжээ эрс буурчээ. Үүний зэрэгцээ хууль хэрэгжиж, санхүүгийн байгууллагын хураамж, шимтгэл нэмэгдэж, зээлийн хугацаа богиносж, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлсөн байна.
- Хүүний дээд хязгаар тогтоох тохиолдолд санхүүгийн байгууллага нь эх үүсвэрийн зардал, эрсдэл, зээл олгохтой үйл ажиллагааны зардлаа нөхөх, өөрсдийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор хүүний бус орлого болох зээлийн хураамж, шимтгэлийг нэмэгдүүлж, зээлийн даатгал зэрэг нэмэлт үйлчилгээ авахыг

зээлдэгчээс шаардаж эхэлдэг олон улсын жишээ байна. Эдгээр нь зээлдэгч, ялангуяа санхүүгийн боловсрол багатай зээлдэгч зээлийн нийт зардлыг тооцоход илүү төвөгтэй болгох бөгөөд зээлийн зардлын ил тод байдлыг бууруулдаг байна.

- Зээлийн хүүний дээд хязгаар тогтоосны дараа жижиг, дунд хэмжээний санхүүгийн байгууллагын хувьд эх үүсвэр татан төвлөрүүлэхэд хүндрэл учрах, зах зээлээс шахагдах, ашигт ажиллагаа нь огцом буурч, цаашид үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлж чадахгүйд хүрэх эрсдэл өндөр юм. Санхүүгийн байгууллагын зээл олголтын хэмжээ, ашигт ажиллагаа, активын өгөөж нь буурахын зэрэгцээ чанаргүй зээлийн хэмжээ нэмэгддэг нөхцөл байдал цаашид удаан үргэлжилбэл зах зээлд эрсдэл хуримтлагдах, санхүүгийн зах зээл тогтворгүй байдалд орох сөрөг нөлөөтэй ажээ.

- Мөнгөний бодлогын хэрэгжилтийн үр нөлөө, төв банкны зорилтоо хангах боломжийг хязгаарлах, төв банкны бие даасан, хараат бус байдал байдалд сөргөөр нөлөөлнө. Тодруулбал, бодлогын хүүг ашиглан зах зээл дээрх хадгаламж, зээлийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах боломж хязгаарлагдана. Санхүүгийн байгууллагын зээлийн хүү, хэмжээний шийдвэрт бодлогын хүүнээс гадна бусад хязгаарлалт, эрсдэл илүү хүчтэй нөлөөлнө.

Дөрөв. Зах зээлд хүү тогтох тогтолцоонд хууль тогтоох байгууллага шууд оролцож, чөлөөт эдийн засгийн зарчмаас ухрах нь олон улсын санхүүгийн байгууллагуудын өмнө Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай харшлахын зэрэгцээ гадаад зах зээлээс хямд өртөгтэй эх үүсвэрийг татах, гадны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд зорилтод ч сөргөөр нөлөөлөх болгоомжлол байна.

Тав. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай эрх зүйн орчныг олон улсын жишгийн дагуу боловсронгуй болгох ёстой. Монголбанкнаас “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулж, өргөн барих бэлтгэл ажлыг хангаж байна. Харин одоо өргөн баригдсан хуулийн мөнгө хүүлэлттэй тэмцэх зохицуулалт дээр илүүтэй анхаарах шаардлагатай байна.

Зургаа. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх, мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөөг сайжруулах, банкны эрсдэл удирдах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулах замаар зээлийнхүүгбууруулахболомжтой. Эдийн засаг, санхүү, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх замаар зээлийн хүүг зах зээлийн зарчимд тулгуурлан бууруулах зорилготой боловсруулсан “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”, түүний үйл ажиллагааны төлөвлөгөөг

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-өөр батлуулаад байна. Энэ стратегийг амжилттай хэрэгжүүлэх нь санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, хүү буурах макро орчинг бүрдүүлэхийн зэрэгцээ зээлийн хүү дорвитой буурч, тогтвортой байхад нөлөөлнө. Ялангуяа, энэхүү дунд хугацааны стратеги нь улс төрийн орчноос үл хамааран манай орны эдийн засгийн бодлогод тогтвортой хадгалагдан хэрэгжиж үр дүнд хүрэх учиртай.

Долоо. Монгол Улсын СТБЗ-өөс баталсан “Чанаргүй активыг бууруулах стратеги”, түүний үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь санхүүгийн зуучлал өргөжих, зээлийн хүү буурах болон санхүүгийн тогтвортой байдал хангагдахад чухал байна. Чанаргүй зээл нэмэгдэхийн хэрээр банкнаас олгох зээлийн хэмжээ, санхүүгийн зуучлал хумигдаж, зээлийн хүү өндөр түвшинд хадгалагдаж, эдийн засгийн идэвхжил сулрахад нөлөөлнө. Иймд чанаргүй зээлийг

үр ашигтай шийдвэрлэх эрх зүйн орчныг тус стратегийн дагуу бий болгох нь олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэн санхүүгийн зуучлалыг өргөжүүлж, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх учиртай.

Найм. Зээлийн хүү өндөр байхад санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зардлаас гадна эх үүсвэрийн хүү, зардал өндөр байгаа нь гол хүчин зүйл болж байна. Ялангуяа хадгаламжийн зах зээл дээрх хэт төвлөрөл, түүнээс үүдэлтэй эх үүсвэрийн зардал өндөр байгаа асуудлыг шийдвэрлэх нь тун чухал байна. Иймд зах зээл, эдийн засагт гажуудал үүсгэхгүйгээр эх үүсвэрийн зардлыг бууруулах шийдэл олох шаардлагатай байна. Энэ чиглэлд бодлогын хэрэгслийг оновчтой ашиглахаар Монголбанк эрэл хайгуул хийн ажиллаж байна.

МОНГОЛБАНК

2019 оны тавдугаар сарын
1-ний өдөр

Монголбанк 2019 оны эхний 6 сарын байдлаар дуустал 6 тн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 7.1 тн үнэт металл худалдан авснаас 1.1 тонноор бага буюу 16%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 6 дугаар сард 1.8 тн үнэт металл худалдсан авснаас Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 168 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 84 кг үнэт металлыг худалдаж авсан байна. Нийт дүнгээрээ өмнөх оны мөн үед 2.2 тн үнэт металл худалдан авч байснаас 396 кг-аар буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 6 дугаар сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 115,314.66 төгрөг байлаа.



График 1. 2018-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны сарын мэдээ (кг)




График 2. 1990-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (тонн)



График 3. 2019 оны 6 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг)



ШАШИН ТӨРИЙГ
ХОСЛОН БАРИГЧ НАРАНГЭРЭЛТ
БОГД ХААНЫ МӨНГӨН ТАМГА

ХОСГУЙ ҮНЭТ

1911 он

Жин: 5890 гр

Өндөр: 12.5 см, 11.7 x 11.7 см

Зузаан: 3.3 см

Мөнгө, цутгамал